

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-40

1.Гадаад харилцааны яамны 2025 оны үйл ажиллагааны талаарх Гадаад харилцааны сайдын мэдээлэл сонсох 4-29

2.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан 29-40

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
4 дүгээр сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 39 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Бум-Очир, Х.Жангабыл;

Чөлөөтэй: Ч.Анар, Н.Батсүмбэрэл, Л.Гантөмөр, С.Лүндэг, Ж.Энхбаяр;

Тасалсан: Э.Бат-Амгалан, З.Мэндсайхан, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ.

**Нэг.Гадаад харилцааны яамны 2025 оны үйл ажиллагааны талаарх
Гадаад харилцааны сайдын мэдээлэл сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, мөн яамны Консулын газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бат-Орших, Бодлогын газрын захирал Г.Бямбасүрэн, мөн газрын Дипломат сургалт, судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга Б.Мөнхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, мөн албаны зөвлөх С.Дунжидмаа, референт Б.Гандиймаа, А.Наранцэцэг, Хяналт, шалгалтын газрын ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн нар байлцав.

Гадаад харилцааны яамны 2025 оны үйл ажиллагааны талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Г.Хосбаяр, Б.Тулга, П.Наранбаяр, Д.Цогтбаатар, Э.Болормаа, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, мөн яамны Консулын газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бат-Орших, Бодлогын газрын захирал Г.Бямбасүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга, П.Наранбаяр, Д.Цогтбаатар, Э.Болормаа, Г.Тэмүүлэн нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Гадаад харилцааны яамны 2025 оны үйл ажиллагааны талаарх Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгийн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, мөн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраа, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Ү.Ганболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Г.Эрдэнэбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, мөн албаны зөвлөх С.Дунжидмаа, референт Б.Гандиймаа, А.Наранцэцэг, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын зөвлөх Б.Алтантуяа, мөн газрын судлаач-ажилтан Г.Анужин, Хяналт шалгалтын газрын ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн нар байлцав.

Тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцлээ.

Уг асуудлыг 17 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 04 минут үргэлжилж, 29 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 62.1 хувийн ирцтэйгээр 17 цаг 43 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
15 цаг 39 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна. Та бүхэнд ирцийг танилцуулъя.

Энхбатын Болормаа гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Ганбатын Очирбат гишүүн, Буяагийн Тулга гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Дамдины Цогтбаатар, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин, Равжихын Эрдэнэбүрэн нарын гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны ирц бүрдсэн байна.

Ингээд 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 2 асуудал байгаа мэдээлэл сонсох.

Нэгдүгээр асуудал, Гадаад харилцааны яамны 2025 оны үйл ажиллагааны талаарх Гадаад харилцааны сайдын мэдээллийг сонсох байна.

Хоёрт, Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг сонсохоор байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэгдүгээр асуудал, Гадаад харилцааны яамны 2025 оны үйл ажиллагааны талаарх Гадаад харилцааны сайдын мэдээллийг сонсьё.

Та бүхэнд өнөөдрийн тайлан, мэдээлэлтэй холбоотойгоор хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Гадаад харилцааны сайд Батцэцэг сайд, Төрийн нарийн бичгийн дарга Мөнхтүшиг дарга, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал Бямбасүрэн, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Бат-Орших, Гадаад харилцааны яамны Гадаад бодлогын Дипломат сургалт, судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга Мөнхбаяр гэсэн бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна.

Манай газрын дарга нар тийшээгээ суугаарай. Микрофонууд руу урагшаагаа очоод суугаарай. Гадаад харилцааны сайд Батцэцэг сайдыг микрофонд урьж байна. Батцэцэг сайд мэдээлэл хийнэ.

Б.Батцэцэг: Сайн байцаана уу? Эрхэм Байнгын хорооны дарга болон гишүүд та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Гадаад харилцааны яамны жил гаруйн өмнө 2024 оны 12 сарын 18-нд Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүдийг Гадаад харилцааны яамандаа хүлээж авч манай улсын гадаад бодлого, үйл ажиллагааны талаар ярилцаж, санал солилцож, зарим саналуудыг нь бас гишүүдээсээ авсан.

Ингээд гадаад харилцаатай холбоотой гацсан асуудлуудыг урагшлуулах, Монгол Улсын эрх ашигт нийцэхгүй асуудлыг өөрчлөн шинэчлэх зэрэг асуудлаар дотроос адил ярилцаад ойлголтын зөрүүг арилгах, нэгдсэн ойлголтод хүрэх, энэ хүрсэн ийм уулзалт байсан гэж бодож байна. Ингээд 2025 оны айлчлал, арга хэмжээнүүдийн талаар товчхон мэдээлэл хийе.

Юуны өмнө өнгөрсөн жил тоймтой хэдэн ажлуудыг танилцуулъя. 2025 онд Турк, Итали улстай стратегийн түншлэл, Чех, Польш, Узбекистан, Киргиз улстай иж бүрэн түншлэлийн харилцааг тогтоосныг төрийн тэргүүний түвшинд хэрэгжүүлсэн төрийн айлчлалуудын үеэр албажуулж, олон нийтэд зарласан.

Өнгөрсөн онд Эсвантин, Барбадос, Тринадад, Ботсвана зэрэг 4 улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлуулсан. Ингэснээр Монгол Улс НҮБ-ын 192 гишүүн улстай, 3 ажиглагч улстай дипломат харилцаа тогтоож, дэлхийн НҮБ-ын бүх гишүүн улсуудтай дипломат найрсаг харилцаа тогтоосон цөөхөн улсын нэг болсон. Энэ нь манай гадаад бодлогын үзэл баримтлалын чухал зорилго байсан.

Өнгөрсөн онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн түвшинд 17, Улсын Их Хурлын даргын түвшинд 5, Ерөнхий сайдын түвшинд 3, Гадаад харилцааны сайдын түвшинд 18 айлчлал, арга хэмжээг хэрэгжүүлж, Засгийн газар хоорондын Комиссын 9 хуралдааныг зохион байгуулж, Гадаад харилцааны яам хоорондын 19 зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Мөн Засгийн газар хоорондын 26 баримт бичиг байгуулах ажлыг зохион байгууллаа. Мөн байгууллага хоорондын 157 гэрээний төслийг хянаж, санал өгөн гэрээ байгуулах зөвшөөрлийг олгосон. Эдгээр өндөр дээд түвшний айлчлал, арга хэмжээг өмнөх 2024 он онтой харьцуулахад манай улсын гадаад харилцаа, манай яамны үйл ажиллагааны цар хүрээ жилээс жилд улам идэвхжин өргөжиж байгааг энэ графикаас бас харж болно.

Тус яамны 2025 оны үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг энэ оны эхээр албан бичгээр байнгын хорооны даргад хүргүүлсэн учраас хийсэн ажлуудыг нэг бүрчлэн тоочих шаардлагагүй гэж бодож байна. Харин зарим айлчлал, арга хэмжээг онцлон танилцуулъя.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Оросын Холбооны Улстай иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх хүрээнд өндөр дээд түвшний яриа, хэлэлцээнд давтамжийг хадгалах бүх салбарын хамтын ажиллагааг идэвхтэй урагшлуулж, тодорхой үр дүнд хүрсэн гэж үзэж байна. Ерөнхийлөгч Хүрэлсүх 2025 оны 9 дүгээр сард Бүгд Найрамдах Хятад Ард Улс болсон ШХАБ-ын гишүүн орнуудын дээд хэмжээний уулзалт, өргөтгөсөн хуралдаан, Хятадын ард түмний Японы түрэмгийллийн эсрэг дайнд ялалт байгуулсны 80 жилийн ойн арга

хэмжээнд тус тус оролцож, энэ үеэрээ Хятад Бүгд Найрамдах Хятад Ард Улсын даргатай хоёр талын уулзалт хийж хамтын ажиллагааны 5 баримт бичиг байгуулсан.

Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны даргын урилгаар бас 2 дугаар сард албан ёсны айлчлал хийж, Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ мөн 2 дугаар сард Харбин хотноо болсон 9 дэх удаагийн Азийн өвлийн наадмын хаалтын үйл ажиллагаанд оролцох үеэрээ Ерөнхий сайд Ли Цянтай бас уулзалтуудыг тус тус хийсэн. Энэ үеэрээ Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын шав тавих ёслолд бас оролцсон байгаа.

Ерөнхийлөгч 5 дугаар сард Оросын Холбооны Улсад болсон Эх орны дайны ялалтын 80 жилийн ойн арга хэмжээнд оролцонгоо Путин Ерөнхийлөгчтэй дээд түвшний улс төрийн хэлэлцээг хийв.

Мөн Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан 7 дугаар сард Женев хотноо болсон Дэлхийн парламентын дарга нарын 6 дугаар Бага хуралд оролцохдоо Оросын Холбооны Улсын Төрийн зөвлөлийн дарга Матвиенкотой уулзаж хоёр орны харилцаа, парламент хоорондын хамтын ажиллагааны зарим асуудлаар бас ярилцсан.

Ерөнхий сайд Занданшатар Путин Ерөнхийлөгчийн урилгаар 9 дүгээр сард болсон Дорны эдийн засгийн чуулга уулзалтад хүндэт зочноор оролцож, нэгдсэн хуралдаанд үг хэлж, дээд хэмжээний уулзалтынхаа үеэр хоёр улсын худалдаа, эдийн засаг, түүний дотор төмөр зам, эрчим хүч, хийн хоолой салбарын хамтын ажиллагааны томоохон төсөл, хөтөлбөрүүдийг эрчимжүүлэх талаар ярилцсан.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын хөрш орнуудтайгаа Засгийн газрын түвшинд олон жилийн туршид ярьж ирсэн худалдаа, эдийн засаг, эрчим хүч, эрдэс, соёлыг, дэд бүтэц зэрэг салбарын хамтын ажиллагааг урагшлуулах ажлуудыг зохион байгуулсан.

Бээжин хотноо 3 улсын төрийн тэргүүн нарын 7 дахь уулзалтыг 9 дүгээр сарын 2-нд зохион байгуулж, Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг дахин 5 жилээр буюу 2031 он хүртэл сунгаж, мөн Оросын Холбооны Улсаас Монгол Улсын нутгаар дамжуулах Бүгд Найрамдах Хятад Ард Улсад дамжуулах хийн хоолойн төслийг хэрэгжүүлэхээр эцэслэн тохиролцсон. Тайлангийн хугацаанд эрчим хүчний асуудал, ялангуяа байгалийн хий дамжуулах хоолой барих төслийн асуудлаар яриа, хэлэлцээг үргэлжлүүлж Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулах энэ байгалийн хийн хоолойн төслийг урагшлуулж, Улаанбаатар хотыг хийжүүлэх төсөлд хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар болон “Газпром” компани хооронд баримт бичиг байгуулсан.

Америк, Ойрх Дорнод, Номхон далайн орнуудтай хөгжүүлж байгаа харилцааны тухайд бол Америкийн Нэгдсэн Улсад Стратегийн гуравдагч түвшний хөршийн түншлэлийг бэхжүүлэх хүрээнд 2 талын харилцаа, хамтын ажиллагааг харилцан ашигтай салбарт гүнзгийрүүлэх, үүнтэй холбоотойгоор Америкийн Нэгдсэн Улсад Гадаад харилцааны сайд айлчилж Төрийн нарийн бичгийн дарга Марко Рубиотой 5 дугаар сард утсаар ярьж, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганы үеэр Төрийн нарийн бичгийн даргын орлогч Ландаутай уулзаж хоёр орны харилцааны асуудлуудаар ярьсан. Энэ үеэрээ Мянганы сорилтын сангийн 2 дахь

компакт гэрээг хугацаанд нь дуусгах, стратегийн ач холбогдол бүхий импортын зарим бараа, бүтээгдэхүүний төлбөр тооцооны тусгай зөвшөөрлийг сунгах, хариуцлагатай аялцаа аяныг үргэлжлүүлэх зэрэг асуудлыг ярилцаж тохирсон.

Өнгөрсөн хугацаанд хийсэн уулзалт, айлчлалуудын үр дүнд Улаанбаатар хотын энэ хаягдал ус боловсруулах анхны үйлдвэр саяхан ашиглалтад орсон. Ингэснээр 18 сая гаруй шоо метр буюу хотын орон сууцад амьдарч байгаа 100 мянган өрхийн жилийн хэрэглээний 50 хувьтай тэнцэх хэмжээний гүний цэвэр усыг хэмнэх энэ үйлдвэр ашиглалтад орсон. Энэ компакт гэрээ 5 дугаар сард, сая 4 дүгээр сард ингээд ашиглалтад ороод Америкийн Нэгдсэн Улсаас бас төлөөлөн ирсэн.

Мөн Монголын Англи хэлний багш, сурган хүмүүжүүлэгчдийг чадавхжуулах, Англи хэлний мэргэжлийн төвийг Монгол улсын их сургууль дээр байгуулсан. Энэ өдрийн байдлаар 250 орчим Монгол багш нар энэ сургалтад хамрагдаад байна. Мөн АНУ-ын “United Airlines” компани Токио-Улаанбаатар чиглэлд анх удаа улирлын нислэг үйлдэж эхэлсэн.

Тайлангийн хугацаанд Ойрх Дорнодын орнуудтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, эрх зүйн орчныг бэхжүүлэх, хөрөнгө оруулалт татах зорилгын хүрээнд бас идэвхтэй ажиллалаа. Оманы Султант Улс, Саудын Араб, Бахрейн Халал махны гэрчилгээг албан ёсоор бүртгүүлж, Кувейтийн талтай амьд мал экспортлох эрүүл мэндийн гэрчилгээг тохирч, 2025 онд манай улсаас Катар 64 тонн, Кувейтэд 11 тонн мах тус тус экспортолж, Кувейтийн мах импортлогчдын “Юнайтед Мидс” компани нь Монголд 3 сая гаруй ам.долларын хөрөнгө оруулалт хийлээ.

Сэргээгдэх эрчим хүчний дэлхийн томоохон компани болох Саудын Арабын “Аква повер” компанийн удирдлага бас Монголд айлчилж, Монголд 10 гегаваттын хүчин чадалтай сэргээгдэх эрчим хүчний дэд бүтэц барих төсөл хэрэгжүүлэхээр эцэслэн тохирлоо. Улаанбаатар шинэ Хархорин хотын чиглэлийн 291км газарт давтан барих төслийн хүрээнд Улаанбаатар-Лүн чиглэлийн авто замын 101км хэсэгт тус тус Кувейтийн болон Булангийн бусад орны хөгжлийн сангуудаас санхүүжилт авах ажил үргэлжилж байна.

Олон улсын харилцааны Номхон далайн бүс нутгийн стратегийн ач холбогдол нэмэгдэж байгаа бөгөөд тус бүс нутгийн тэргүүлэгч орнууд болох Австрали, Шинэ Зеланд зэрэг улстай харилцаа хамтын ажиллагааг шинэ шатад гаргахыг зорьж ажиллалаа.

Австралийн амбан захирагч Саманта Мостинын 9 дүгээр сард Монгол Улс төрийн айлчлал хийсэн. Австралийн Засгийн газрын тэтгэлгийн квотыг нэмэгдүүлж, талууд агаарын харилцааны хэлэлцээрийг эцэслэж, нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр байгуулах ажлыг эхлүүлсэн. Мөн Шинэ Зеланд Улстай дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн хүрээнд Шадар сайд бөгөөд Гадаад хэргийн сайд Монгол Улсад айлчилж, Парламентын төлөөлөгчдийн танхимын дарга Жерард Браунли 8 дугаар сард бас тус тус Монгол Улсад айлчилж, энэ үеэр итгэлцлийг гүнзгийрүүлэх.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Микрофон нэмж өгье. Батцэцэг сайд.

Б.Батцэцэг: Тэр дундаа хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагаа дээр нэлээд ахицтай ажлууд гарсан байгаа. Ингээд Азийн орнуудтай хөгжүүлэх харилцаан дээр Япон Улсын түүхэн айлчлал болсон Японы цог жавхлантай Эзэн хаан, эрхэм дээд хатан нар Монгол Улсад төрийн айлчлал хийж, Монгол Улс, Япон Улсын хүн төвтэй тусгай стратегийн түншлэлийг гүнзгийрүүлэх, ард иргэдийн хоорондын найрамдал, нөхөрлөлийг батжуулах, бэхжүүлэхэд түүхэн ийм ач холбогдолтой айлчлалыг хийгээд араас нь Гадаад харилцааны сайд Япон Улсын Гадаад харилцааны яамны урилгаар айлчлалыг хэрэгжүүлээд, айлчлалын хүрээнд Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжих 545 сая иений үнийн дүн бүхий 2 солилцох нот бичгийг гарын үсэг зурлаа. Мөн Япон Улсын Засгийн газраас манай улсад үзүүлж байгаа Хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээний иений хөнгөлөлттэй зээлийг эргэн сэргээлээ.

Бүгд Найрамдах Солонгос Улсын хооронд 35 жилийн дипломат харилцаа тогтоосны ой болсон. Хоёр улсын Ерөнхийлөгч нар 9 дүгээр сард утсаар ярилцаж тус улсын Ерөнхийлөгч 2026 онд Монгол Улсад айлчлахаа нотолсон байгаа.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн дарга 4 дүгээр сард Монгол Улсад албан ёсны айлчлал хийж, хоёр улсын парламентын дарга нар 7 дугаар сар Женев хотноо уулзсан. Хууль тогтоох байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэхэд бас чухал ач холбогдолтой байсан.

Энд Монгол Энэтхэгийн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэхэд 10 дугаар сард Бүгд Найрамдах Энэтхэг Улсад Монгол Улсын Ерөнхийлөгч төрийн айлчлал хийсэн. Энэ үеэр 9 баримт бичигт талууд гарын үсэг зурж, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг урагшлуулах асуудлаар болон төлбөр тооцоог цаашид хэрхэн хийх талаар Энэтхэгийн Засгийн газартай зарим зүйлүүдийг тохирсон.

Монгол Улсын Төв Азийн бүс нутаг дахь улс орнуудтай харилцах харилцаа, хамтын ажиллагаа идэвхтэй өрнөж, Туркменистан, Узбекистан, Киргиз, Тажикстан улсуудтай төрийн айлчлалууд хийж харилцаагаа бас сэргээсэн ийм түүхэн жил байлаа. Тухайлбал, Туркменистан болон Узбекистан Улсад Монгол Улсын Ерөнхийлөгч төрийн айлчлал хэрэгжүүлж, 7 дугаар сард Киргиз, Тажикт бас айлчлал хийснээр олон 30-аад жилийн хугацаанд бас хамтарч ажиллаж болох байсан салбаруудаа бүх чиглэлээр хамтын ажиллагаагаа ярьж, олон баримт бичиг зурсан байгаа.

Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан Бүгд Найрамдах Казакстан Улсад бас 9 дүгээр сард албан ёсны айлчлал хийсэн. Парламентын Мажлис хоорондын хамтын ажиллагааны санамж бичигт зурснаар Монгол Казахстаны ажил хэргийн зөвлөлийн 2 дугаар хуралдааныг бас зохион байгуулж, хоёр талын 150 гаруй бизнесийн төлөөлөл оролцсон.

Европын орнуудтай Монгол Улсын Ерөнхийлөгч Турк, Чех, Польш, Итали, Грек, Гэгээн Ширээт улсад төрийн айлчлал хийж, нөгөө талаас Бүгд Найрамдах Австри Улсын Ерөнхийлөгч Монгол Улсад төрийн айлчлал хийлээ.

Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж байгаа Хүнсний хангамж, аюулгүй байдал, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Илгээлт 2100” зэрэг санаачилгын хүрээнд хамтран ажиллах харилцааны бэлэг тэмдэг болохуйц төсөл, хөтөлбөр

хэрэгжүүлэх, үндэсний хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд үр дүнтэй яриа хэлэлцээнүүд боллоо.

Их Хурлын дарга Амарбаясгалан Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс бусад албан ёсны айлчлал хийж, Улсын Их Хурлын даргын түвшинд тус улсад хийсэн албан ёсны анхны айлчлал болж, хувь тогтоох байгууллага, парламентын бүлэг хоорондын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн тэлэх, харилцан сонирхсон салбарууд хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд бас таатай орчныг бүрдүүлсэн гэж үзэж байна.

Эдгээр айлчлалууд үр дүн эхнээсээ гараад эхэлсэн. Тухайлбал Австри Улсын Ерөнхийлөгч 5 дугаар сард манай улсад хийсэн төрийн айлчлалын үеэр.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Микрофон нэмээд өгөөрэй. Минутыг нь мэдээллийг дуустал өгье.

Б.Батцэцэг: Австри Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэс визийн хэлэлцээр хүчин төгөлдөр болж, энэ оноос эхлэн манай улсын цахим албан паспорттой эзэмшигчид Австри Улс руу 90 хоног визгүй зорчих болж байгаа.

НҮБ болон олон улсын бусад байгууллагуудын хамтын ажиллагаанд идэвхтэй байр сууриа илэрхийлж, олон улсын тулгамдсан асуудлуудаар бас Монгол Улсын байр суурийг илэрхийлж Монгол Улсын санаачилга, зорилтыг бас олон талт тавцанд уялдуулан хэрэгжүүлэхийг бас зорилтоо болгож ажилласан. Монгол Улсын Ерөнхийлөгч Нью-Йорк хотноо болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулган мөн тус байгууллагын 80 жилийн ойн өндөр түвшний хуралдаанд оролцож, тэргүүлэх чиглэл, нийгэм эдийн засгийн бодлогод тулгарч байгаа сорилтуудыг даван туулах хүчин чармайлтынхаа талаар танилцуулсан.

Жил бүрийн 7 дугаар сарын 11-ний өдрийг “Дэлхийн адууны өдөр” болгон тунхагласан НҮБ-ын шийдвэрийн хэрэгжилт 2025 оноос албан ёсоор эхэлж адууны соёл, нүүдлийн өв уламжлалыг дэлхийн түвшинд сурталчлах манай улсын бодлогын бодит илэрхийлэл болсон.

Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаар талаарх Улаанбаатарын яриа хэлэлцээ олон улсын 10 дугаар бага хурал 6 дугаар сард амжилттай зохион байгуулж, бүс нутгийн 30 гаруй улс, олон улсын байгууллага, судалгааны хүрээлэнгийн 200 гаруй төлөөлөгч Солонгосын хойгийн байдал, бүс нутгийн аюулгүй байдал, итгэлцэл, уур амьсгалын өөрчлөлт, ногоон хөгжлийн асуудлаар нээлттэй санал солилцлоо.

Монгол Улс Зүүн Ази, Латин Америкийн хамтын ажиллагааны форумыг Зүүн Азийн бүсийг 25-27 онд хамтран даргалах Доминикан Улстай ажил эхэлсэн. Улмаар “FEALAC”-ын Гадаад хэргийн сайд нарын 10 дугаар уулзалтыг 25 жил ба цаашдын төлөв, Зүүн Ази, Латин Америкийн хамтын ажиллагааны алсын хараа сэдвийн дор 8 дугаар сард амжилттай зохион байгуулсан. Энэ үеэр Улаанбаатарын тунхаглал баримт бичгийг гаргасан байгаа.

Олон улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хувьд Оросын Холбооны Улсын эсрэг тогтоосон эдийн засгийн хориг арга хэмжээг зөрчихгүйгээр худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг үргэлжлүүлэх нефтийн

бүтээгдэхүүний импортын төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэхэд онцгой анхаарал хандууллаа.

Япон Улсад “Осака-Кансай экспо 2025”-д дэлхийн үзэсгэлэн зохион байгуулагдаж манай улс Монголын их амар амгалан “Рах Mongolica” гээд сэдвийн хүрээнд павильон нээж оролцсон бөгөөд Японы болон бусад гадаад улс орны зочдод 6 сарын хугацаанд танилцууллаа.

Үзэсгэлэн ажиллах хугацаанд олон 10 соёлын болон улс орноо танилцуулах арга хэмжээ зохион байгуулсны дотор 7 дугаар сарын 27-нд Монгол Улсын үндэсний өдөрлөг арга хэмжээг зохион байгуулсан.

Минск хотноо 6 дугаар сард бас Евроазийн эдийн засгийн дээд зөвлөлийн хуралдаанд Монгол Улс, Евро Ази эдийн засгийн холбоо хооронд чөлөөт худалдааны түр хэлэлцээр байгуулж, гарын үсэг зурж, 2025 оны сүүлээр Улсын Их Хурлаар соёрхон батлуулсан.

Олон улсын болон бүс нутгийн түвшинд худалдаа, эдийн засгийн хамтын аж ажиллагааг идэвхтэй өрнүүлэх хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Дэлхийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг 8 дугаар сард зохион байгуулж, 20 гаруй улсын Засгийн газрын төлөөлөгчид, парламентын гишүүд, олон улсын байгууллагын удирдлага бизнесийн салбар, бизнес эрхлэгч нийт 250 гаруй гадаадын зочид, төлөөлөгчид дотоодын 500 бизнес эрхлэгч эмэгтэйчүүд оролцлоо.

Энэ үеэр “WEIDE” сангаас эмэгтэй удирдлагатай 50 аж ахуйн нэгжид 1 сая ам.долларын буцалтгүй тусламжийг олгосон нь Монголын бизнес жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, олон улсын зах зээлд нэвтрэхэд нь бас бодит дэмжлэг болсон.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Дэлхийн Монголчуудын наадмыг Брюссель хотноо 6 дугаар сард зохион байгуулж, гадаад, дотоодын 15 мянга орчим наадамчид оролцсон. Иргэдэд хүргэх консулын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, цахимжуулах ажлын хүрээнд Англи хэл дээрх 12 төрлийн лавлагаа, тодорхойлолтод цахим Апостиль гэрчилгээг “E-Mongolia” системээр дамжуулан 9 дүгээр сараас олгож эхэлсэн.

Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах санд 2025 онд улсын төсвөөс 600 сая төгрөг төсөвлөгдсөн нь 25 оны сангийн зөвлөл 7 удаа хуралдаж, хилийн чанадад нас барсан 29 иргэний шарил, чандрыг эх оронд нь авчрах болон бусад заалтыг үндэслэн 236 иргэнд нийтдээ 526 сая 827 мянган төгрөгийн тусламжийг үзүүлсэн.

Олон улсын харилцааны энэ олон улсын нөхцөл байдлыг бүгд мэдэж байгаа юм чинь энийг хэмнээд Монгол иргэдийг Ойрх Дорнодод үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор Монгол иргэдийг татан авах ажлыг өнгөрсөн жилээс эхлээд зохион байгуулсан. Нийтдээ 469 иргэн энэ Ойрх Дорнодын бүс нутагт байгаа. Үүнээс байнга оршин сууж байсан 321, түр хугацаагаар зорчиж байсан 148 иргэн байсан.

Ойрх Дорнодын оронд байгаа эх орондоо буцах хүсэлтэй иргэдийн хүсэлтийг авч Гадаад харилцааны яам, Зам, тээврийн яам, “МИАТ” компанитай хамтарч энэ оны 3 дугаар сарын 10-нд зохион байгуулж, иргэдээ татаж авсан

байгаа. Татан авах ажиллагааг зохион байгуулахад 200 орчим. Энэ шууд нислэг зохион байгуулсан. Үүнээс өмнө ба бас Израилаас бид нар тодорхой тооны иргэдийг бас татаж авсан байгаа. Иранд Монгол иргэн байхгүй. Иранд нийтдээ холимог гэр бүлийн 2 иргэн байсныг бол бид нар бас татаж авсан байгаа.

Куба Улсын нөхцөл байдал Кубад нийтдээ 12 оюутан сурч байгаа. Буцах иргэд нь буцсан. 12 иргэдтэй байнгын холбоотой, ар гэртэй нь холбоотой өөрсдөө одоогоор ирэх хүсэлтээ гаргаагүй байгаа.

Хилийн чанадад байгаа Монгол иргэдийн талаар бас товчхон танилцуулъя.

Бүгд Найрамдах Солонгос Улсын хилээс Монгол иргэдийг буцаагдаж байгаа асуудал нэлээд олон дахиж яригддаг. Энийг бид нар бүхий л түвшинд өнгөрсөн 4, 5 жилийн хугацаанд Солонгосын Засгийн газартай ярьж байгаа. Хил дээрээс буцаж ирж байгаа иргэдийн тоо 2023 онд 1487, 2024 онд 1350, 2025 онд 1104 байгаа буюу өнгөрсөн жилээс зорчиж байгаа иргэдийн тоо нэмэгдэж, буцаагдаж байгаа иргэдийн тоо буурч байгаа. Ингээд 2025 онд 166647 иргэн Солонгос Улсад зорчсоны 1104 буюу 0.65 хувь нь хил дээрээс буцаагдсан байна.

Гадаад харилцааны яамны хувьд энэ асуудлыг олон удаа янз бүрийн шугамаар тавьж Гадаад харилцааны сайд, Гадаад харилцааны дэд сайдтай уулзахдаа Элчин сайдтай энэ асуудлыг тавьсан. Энэ тавихдаа бид нар визтэй иргэдийг хил дээрээс үндэслэлгүйгээр саатуулах, албадан буцаах явдлыг зогсоох, виз татгалзсан хариу авсан иргэд 6 сарын хугацаанд дахин виз мэдүүлэх боломжгүй байгааг цуцлах, виз мэдүүлсэн иргэд хариу гартал паспортоо авч чадахгүй зорчих эрх нь хязгаарлагдаж байгааг орлуулах хувилбар ашиглах, виз мэдүүлгийн процессыг манай улстай адилхан цахимжуулах зэрэг асуудлуудыг албан ёсоор тавьсан.

Мөн эмчилгээнд явж байгаа иргэдийг асран хамгаалагчтай нь визийг хурдан олгож байх, албан ажлаар явж байгаа бизнес эрхлэгчдийг бас визийг нь саадгүй болгох энэ асуудлуудыг айлын талд тавиад ажиллаж байгаа.

Айлын талд энэ асуудлуудыг Хууль зүйн яам нь шийддэг. Нэлээн өндөр түвшинд яриад энэ асуудал бас визийн хөнгөлөлтүүд шат дараатайгаар олгоно гэдгийг албан шугамаар бид нарт хариу хэлж байгаа.

Ерөнхий мэдээллүүд ийм байна. Бусад нь асуулт байвал хариулаад явсан нь дээр байх Тэмүүлэн даргаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Батцэцэг сайдад мэдээлэл хийсэнд баярлалаа.

Мэдээлэлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Бид бүхний хувьд энэ Улсын Их Хурлын Дэгийн тухай хуулиар ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын мэдээллийг бол Байнгын хороод бас сонсох ийм бол эрхтэй байгаа. Хуучин бол хагас жил тутамд болон жил бүр бас бусад яг ажлаа шууд тайлагнадаг байгууллагын мэдээллийг сонсох үүрэгтэй байсан нь бол өөрчлөгдсөн байсан.

Тэгэхээр бид нар ямар ч би яг ажлаа шууд тайлагнадаг манай Гадаад харилцааны яам болоод Батлан хамгаалахын яам мэдээллүүдийг бас энэ 7 хоног болоод ирэх 7 хоногийн Байнгын хорооны мэдээлэл сонсох цагууд дээр ингээд

тусгайлж оруулж өгсөн байгаад байгаа. Улс бүрийн нэн тэргүүний бодлого нь өөрөө гадаад бодлого байдаг. Энэ үүднээс ямар нэг алдаа гаргах, мадаг гаргах тийм эрх бол бид нарт байхгүй. Энэ үүднээс бас энэ холбогдох байгууллагуудтай холбоотой мэдээллүүдийг тухай бүр бас сонсож байх болно гэдгийг та бүхэнд бас юуны өмнө мэдээлэл болгоод хэлчихье.

Ингээд гишүүдийн нэрсийг авлаа. Болормаа гишүүнээр тасалъя. Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Ер нь сүүлийн үед ер нь Батцэцэг сайд манай Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүхийн үед манай гадаад харилцаа их сайн байгаа. Ер нь их олон салбаруудыг бид нар болохгүй, бүтэхгүй байна гэж би ярьдаг. Ганц болж байгаа бүтэж байгаа салбар бол гадаад харилцааны салбар байна. Бас манай хамт сонгогдсон манай нутгийн сайд сайн ажиллаж байгаад бас талархалтай хандаж байна. Тэр нь хэд хэдэн зүйлээр илэрхий байна. Тухайлбал нээрээ бас энэ бүх улс орны ялангуяа өндөр хэмжээний зочид Монгол Улсад шил шилээ дараалаад л ирж байна. Япон Улсын эрхэмсэг цог жавхланта хаан хүртэл айлчиллаа шүү дээ. Манайд 3 дахь айлчлалаараа манайхыг сонгож айлчлалаа. Бутаны Хаан айлчиллаа. Энэ онд бас ямар айлчлал байгаа вэ энэ зун? Энийг бас сонсчихмоор байх юм. Тэр нь ч бас дэлхийн хэмжээний бүх анхаарлыг татсан улс орноо сурталчилсан ийм арга хэмжээ болж байна. Энд бас тэмдэглэж хэлэх нь зүйтэй гэж үзэж байна.

193 улс байдаг НҮБ-ын гишүүн бид нар чинь хэдтэй нь дипломат харилцаатай болчихоод байна. Нэлээн тоо нь ихэссэн байх. Нөгөө талаар манай гадаад паспорт ямар байдалтай байна вэ? Гадаад паспортын чинь ранк гээд гаргадаг шүү дээ жил болгон. Сүүлийн үед ямар болсон бэ? Хэчнээн оронд визгүй явж ингэж болж байна вэ? Нэг харамсалтай үйл явц байгаа тэгээд энэ тэр визийн бонд гэдэгт Монгол Улс орчихсон байгаа Америкийн Нэгдсэн Улстай. Америкийн Нэгдсэн Улсад манай их олон иргэд ажиллаж амьдардаг. Залуучууд маань суралцахыг хүсдэг. Тэр болгон бид нар 15, 10 мянган доллар байршуулаад ингээд зорчиход хүндрэлтэй. Энийг шийдэж байгаа байдал байна уу? Нөхцөл байдал ямар байгаа вэ гэсэн ийм хэдэн асуултууд байна.

Нөгөө талаар энэ манай залуучууд бас гадагшаа явж ажиллаж байна. Тэгээд бас гэр бүлээрээ ч явж байна. Заримдаа хүүхэд нь ч хамт явж байна. Үүний Монгол хэлээ мэдэх, Монгол хэлээ суралцах, Монгол соёлтой танилцах, Монгол хүн байх энэ асуудал дээр яаж анхаарч байгаа вэ? Хаа сайгүй л гадаад хэлээр л ярьсан ийм хүүхдүүдтэй болчих гээд байх шиг байна бид нар гэсэн ийм хэдэн асуултууд байна.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүнд баярлалаа. Батцэцэг сайд асуултад хариулъя.

Б.Батцэцэг: Ганбат гишүүндээ баярлалаа. Асуултад нь хариулъя. Төрийн айлчлалууд ерөнхийдөө нууц байдаг. Тэгээд энэ жилийн өндөр дээд хэмжээний айлчлалын төлөвлөгөөнүүд батлагдсан байгаа. Түрүүний график байсан. Бид нарын 24, 25 оны төрийн өндөр дээд айлчлалуудыг харьцуулсан. Тэрнээс харах юм бол тэрнээс буухгүй айлчлалууд хийгдэнэ ээ гэж ойлгох хэрэгтэй. Тэгээд хамгийн түрүүнд зарлаж болохоор айлчил бол ирэх 1 дэх өдөр Казахстанд айлчлах Ерөнхийлөгчийн төрийн айлчлал байгаа. Тэгээд айлчлалаар бол бид нар маш олон баримт бичгүүд байгуулж, гадаад харилцааг яаж иргэн бүрд хүргэх вэ, амьдралд яаж нийцэж байгаа юм гэдгийг тайлбарлахгүй бол баахан айлчлал

хийдэг яам гэдэг ийм нэр зүйлийн үед аваад байгаа. Айлчлал нь өөрөө энэ харилцааны бас оргил нь байдаг. Эрх зүйн орчноо бүрдүүлдэг.

Тэгээд аж ахуйн нэгжүүдэд таатай орчин нь манай гадаад бодлогоо үргэлжлэлийг нь гадаад харилцаагаа, гадаад, дотоод бодлогын үргэлжлэл гэж үздэг учраас харилцаа тухайн улс оронтой харьцах таатай нөхцөлийг эрх зүйн орчныг нь бүрдүүлж байгаа маш чухал харилцааны оргил хэсэг нь юм гэж ойлгох ёстой. Тийм учраас өндөр дээд хэмжээ, ялангуяа төрийн айлчлал бол хамгийн эцсийн тохиролцоо, хамгийн эцэст олон нийтэд 2 орон юу хийх гэж байгаагаа зарладгаараа онцлог. Ингээд энэ төрийн айлчлалууд бол өнгөрсөн жилийнхээс дутахгүй ийм айлчлалууд болно гэдгийг нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарт энэ гадаад паспортын тоог Орших хэлчих үү албан дипломат паспорт, бусад паспортуудыг, бусад асуултад нь би үргэлжлүүлээд хариулъя.

Г.Тэмүүлэн: 8 номер албан тушаал нэрээ хэлээд асуултад хариулаарай.

Т.Бат-Орших: Консулын газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Бат-Орших. Өнөөдрийн байдлаар манайд хэрэглээнд байгаа 7 мянга гаруй албан паспорт байна. Дипломат паспорт 3 мянга гаруй дипломат паспорт ашиглалтад байна.

Г.Тэмүүлэн: Хэн хариулах вэ нэмж? 8 номер.

Т.Бат-Орших: Албан дипломат паспорт 72 улсад визгүй зорчиж байгаа. Бүх төрлийн паспорттой 29 улсад визгүй зорчиж байна. 20 оноос хойш нийтдээ албан дипломат паспорт 8 хэлэлцээр байгуулаад ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Батцэцэг сайд нэмээд хариулт өгье.

Б.Батцэцэг: Тийм, Монгол паспортын чанар сайжирч байгаа. Бид нар айлчлалын үеэр ч гэсэн бүх улс оронтой л нөгөө визийн хэлэлцээр байгуулах ийм ажлуудыг зохион байгуулж байгаа. Өнгөрсөн онд 3 улстай, тэрний өмнө 2 улстай бид нар визээс чөлөөлөх хэлэлцээр байгуулсан хэрэгжээд явж байгаа.

Америкийн визийн бондын асуудал дээр энэ АНУ-ын Трампын Засгийн газрын цагаачлалын бодлоготой холбоотойгоор 50 улсад энэ барьцаа тавих шалгуурыг тавьсан байгаа. Бид нар энийг АНУ-ын Засгийн газарт асуудлаа тавиад хэдийгээр тэр цагаачлалын бодлогыг ойлгож байгаа. Манай иргэдийн тэнчээ хууль бусаар оршин сууж байгаа иргэдийн халамжид хамрагдах байдал болон бусад орнуудтай адилхан нэг категорид оруулж ингэж хассан ч гэсэн харилцааныхаа олсон өнөөдрийг хүртэлх давуу талуудыг үндэслээд бас энэ бод.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн нэмээд тодруулъя. Тэгээд Батцэцэг сайд нэмээд хариулах уу?

Д.Ганбат: Би 1 асуулт асууна. Тэр дээр та нэмээд наад юмнуудаа ярьчихаарай. Энэ юу байна л даа энэ Нарансэвстэй боомт гэж байгаа. Аль дээр үеэс л Хятадын Засгийн газар шийдчихсэн энэ боомтыг нээе ээ гээд. Тэгээд манай талаас л хүлээгээд байдаг. Гэхдээ ард иргэддээ ч гэсэн бид нар ойлголтыг нь зөв өгмөөр юм шиг байгаа юм. Наад тал нь говийн дархан цаазтай газар байдаг. Нөгөө талдаа Хятад талаас дандаа бид нар автономит муж тийм дамжуулсан тийм

улсуудаар холбогддог. Энэ ганцхан нөгөө шууд харьцаж болохоор Гансү мужаар дамжиж холбогддог ийм ач холбогдолтой ийм боомт байгаа. Тэгээд олон жилийн өмнө шийдчихсэн энэ боомтыг бас яах вэ?

Нөгөө талаар бид нар бас Украин улстай гэрээ хэлэлцээ хийгээд иргэд хоорондоо визгүй зорчих ийм.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Батцэцэг сайд асуултад хариулъя.

Б.Батцэцэг: Виза бонд дээр Рубио Төрийн нарийн бичгийн даргад надаас захидал явсан байгаа. Америкийн Нэгдсэн Улсад манай Элчин сайд бас Төрийн департаменттай уулзаж энэ асуудлыг өндөр түвшинд тавьсан. Өөрсдөө бол мэдээж энэ дээр их анхаарал тавих хэрэгтэй юм байна. Бид нар харилцааныхаа түвшнийг харгалзаад энэ асуудлыг хөөцөлдье гэсэн ийм байдалтай байгаа шүү.

Нарансэвстэй боомт дээр Хятадын тал бүтээн байгуулалтаа хийгээд манай талд орон нутагтаа бас нэлээн олон жил ярьж байсан асуудал. Одоогоор энэ яригдаагүй. Энийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс бид нар бас зөвлөмж гаргах ёстой гэж үзэж байгаа. Тэгээд иргэдийн зүгээс нэлээн эсэргүүцэлтэй тулдаг. Одоогоор ямар нэгэн шийдвэр гарсан юм байхгүй. Мэдээж Хятадын тал бол энэ боомтыг нээе гэдэг саналаа тавьсан хэвээрээ байгаа. Энийг өнгөрсөн жил 2 жилийн өмнө бас Гадаад бодлого, аюулгүйн байнгын хороон дээр Засгийн газраас нэг оруулаад тэгээд зогсчихсон байгаа бас. Засгийн газраар хэлэлцээд тэр энэ бүүр өмнөх 24 оны сонгуулиас өмнө шүү дээ, 24 оны сонгуулийн өмнөхөн Байнгын хороогоор хэлэлцэхээр ороод тэгээд зогсчихсон байгаа. Тэгээд тэрнээс хойш бол энэ асуудлыг дахиж яриагүй. Одоо Хятадын талд тавьсан хэвээрээ. Манай тал ямар ч хариу өгөөгүй хэвээрээ байгаа.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн болсон уу? Тэмүүжин гишүүн асуулт асууя. Больчихсон уу тээ? Ойлголоо асуулт давхацсан байна. Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Би 1 дүгээрт нь Японд байгаа Элчин сайдын яам ноднин очиход байрны асуудал нь эрүүл ахуй ашиглалтын шаардлага хангахаа больчихсон энийг Засгийн газрын түвшинд бас ярьж хэлж өгөөч, шийдээч гэж байсан. Энэ дээр ер нь ямар нэгэн шийдэл гарсан уу? Шийдэл гарсан бас хэлж өгөөч гээд.

Дараагийнх нь болохтойгоо зэрэг энэ гадаад худалдаа, экспорттой холбоотой тэр дундаа ноолуур, мах 2-ыг асуух гэсэн юм. Манайх ноднингоос эхлээд ноолуураа угааж самнаад урд хөрш рүүгээ биш Европ руу тэр дундаа Итали руу гаргаж байгаа одоод дараагийн түвшний боловсруулалт хийгээд гаргаж байгаа гэж ингэж ярьж байгаа. Тэгэхээр энэ яг Засгийн газрын түвшинд яриа хэлэлцээртэй ийм ажил байна уу, эсвэл хувийн хэвшлийнхэн өөрсдөө тэр хувийн хэвшилтэйгээ харилцаад энэ ноолуурын салбарт ингээд явж байна уу?

Дараа нь махны экспортлохтойгоо зэрэг мөн л энэ жил чинь бас хөдөө мал, мах давгүй сайн үнэтэй малчдад бас их дэм боллоо. Тэгээд яагаад бас мал мах үнэтэй байна вэ гэхээр нөгөө экспорт сайн хийсэн учраас, бас нэлээд олон улс руу мах экспортолж байгаа учраас бас махны мах үнэтэй байгаа гэдэг ийм зүйлийг хэлж байгаа. Тэгээд бас манай гол мах гаргаж байгаа сүүлийн хэдэн жил бас экспорт хийсэн Иран улс маань бас дайнтай болчихсон байгаа. Тэгэхээр ер нь энэ махны экспорт энэ Ойрх Дорнодын дайнтай холбоотойгоор ер нь бас өөрчлөлт

гарч байгаа юу? Энэ ноолуур, мах хоёрын экспорт, гадаад худалдаан дээр бас хариулт хэлээч.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүний асуултад хариулъя Батцэцэг сайд.

Б.Батцэцэг: Японы байрны асуудал манай Элчин сайдын яам байрлаж байгаа байршлын хувьд маш ашигтай. Тэр газрын үнэ бол тогтмол өсөж байгаа. Бид нар сая манай Элчин сайдын яам бас бүтэн 2 жил ажиллаж байгаад нэг үл хөдлөх хөрөнгө авахаар болоод тэгээд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээд тэр байгаа байраа нэлээн өндөр үнэтэй одоо байгаа байраа зараад тэгээд тэрнийхээ бараг 70 хувиар нь бид нар шинэ байшин аваад яг нэг тойрогт тэгээд доторх тавилга, өшөө дээрээс нь нэмээд өөр Элчин сайдын яаман дээр ч гэсэн байшин авахаар ийм хэмжээний сайн яриа хийж тохирсон боловч хоёр талын Гадаад харилцааны яамдын дотоод процедур зөвшөөрөл өгөх ажил л нь 2-3 сар шаардагддаг юм.

Нөгөө зарж байгаа аж ахуйн нэгж нь хүлээж чадахгүй тэр хоёр бас их ашигтай байр байсан учраас ингээд зарагдсан харамсалтай юм болсон. Тэгээд үргэлжлүүлээд манай Эрүүл мэндийн яамныхан адилхан тийм байр хайж байгаа. Шийдвэрийн хувьд бол улсын төсвөөс мөнгө гаргаж чадахгүй. Улсын төсвөөс мөнгө гаргасан тохиолдлоор байж 20-30 тэрбум төгрөг зарцуулахаар байгаа. Тийм учраас түрүүний ярьсан байдлаар зохицуулахаар ийм шийдвэрийг Засгийн газраас гаргасан. Үргэлжлүүлэн хөөцөлдөж байгаа.

Хоёрдугаарт нь ноолуур бид нар дэлхийн ноолуурын зах зээлийн 50 хувийг Монгол Улс дангаараа хангадаг боллоо. 3 жилийн дотор гэж аж ахуйн нэгжүүд Худалдаа аж үйлдвэрийн танхим, Гадаад харилцааны яам ийм тоо тооцоог гаднынханд ярьдаг. Барууны орнуудад ноолуур, ноос экспортлох ажлыг голлож Гадаад харилцааны яам, дипломатууд, Элчин сайдын яамнууд зохион байгуулж аж ахуйн нэгжүүд хэрэгжүүлж байгаа. Аж ахуйн нэгжүүдийн дэмжлэг үзүүлж бараа, бүтээгдэхүүнүүдээ гаргах энэ эрх зүйн орчныг нь бүрэн бүрдүүлсэн. Ноолуурын хувьд одоо экспорт дээр нь ямар нэгэн асуудал, саад байхгүй. Бид нар бүх төрийн айлчлал, жижиг, том айлчлалууд дээр дагаад бизнес форумуудыг зохион байгуулах, бизнесийнхэнд туслах ажлуудыг зохион байгуулж байгаа.

Махны экспорт дээр Арабын Ойрх Дорнодын орнууд, Иран, Төв Азийн орнууд, Вьетнамд мах гарч эхэлсэн. Энэ бас энэ олон хэлэлцээрүүдийн үр дүн шууд бодитой хэрэгжиж байгаа. Иранаас бусад орнуудад мах гаргах ажил үргэлжлээд явж байгаа.

Дээрээс нь нэмээд Вьетнамд бас гүн хөлдөөсөн ямааны мах гараад эхэлсэн байгаа. Арабын орнуудад энэ нөгөө хорио цээрийнх нь асуудлууд нь шийдэгдсэн учраас энэ дээр саад гарахгүй махны экспорт дээр.

Иран дээр мэдээж тодорхой хугацаанд гарах ажил нь зогссон байгаа.

Г.Тэмүүлэн: Тулга гишүүн асуулт асууя.

Б.Тулга: Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг эрье. 2 асуулт байна Батцэцэг сайд аа. 2026 оны 1 сард Энх тайвны Зөвлөл гэж АНУ-ын Ерөнхийлөгч Трампын санаачилсан энэ байгууллагад Монгол Улс үүсгэн байгуулагчаар очиж гарын үсэг зурсан Давост. Энэ ямар газрын ямар, Монгол Улсын ямар

байгууллагын шийдвэртэйгээр гэдэг юм уу, зөвшөөрлөөр хаана хэлэлцэгдээд энэ ямар бичиг баримт дээр гарын үсэг зурсан бэ? Энэ бичиг баримтыг энэ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр авч үзэж хэлэлцэхгүй байсан уу? Энэ талаар тодорхой хариулт өгвөл сайн байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт Америкийн Нэгдсэн Улстай Монгол Улс бол стратегийн эдийн засаг, аюулгүй байдлын түвшний стратегийн түншлэлтэй орон гэж бид нар ойлгож байгаа. Сая энэ визийн хөтөлбөрт хамрагдсан 50 улс дотор бол Гүрж манай хоёр үндсэндээ стратегийн түншлэлтэй орнуудаас визийн барьцааны хөтөлбөрт орж байх шиг байна. Миний санаж байгаагаар энэ 10 жилийн виз маань 2004, 2005 онд л эхэлж байсан санагдах юм 10 жилийн виз авдаг болоод. Энэ 10 жилийн виз өгдөг маань хэвээрээ байгаа юу? Энэ визийн бондын хөтөлбөрт орсонтой холбоотойгоор байхгүй болсон уу?

Тэгээд энэтэй холбоотойгоор ер нь энэ, тийм тэгэхлээр энэ 10 жилийн виз өөрөөр хэлбэл манай статус доошлоод байна шүү дээ. Монгол Улсын статус Америктай харилцах энэ статус маань ингээд муудаад гэдэг юм уу, доошлоод байгаа дээр яг хэн хариуцлага хүлээх вэ? Хариуцлага хүлээх субъект бий юу гэдэг ийм асуултыг тавьж байна.

Г.Тэмүүлэн: Тулга гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? 7 номер Бямбасүрэн дарга асуултад хариулъя.

Г.Бямбасүрэн: Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал Бямбасүрэн асуултад хариулъя. Энхийн зөвлөлд элсэх асуудал Олон улсын гэрээний тухай хуульд заасны дагуу бас заавал соёрхон батлах шаардлагатай гэрээ бол биш байсан. Монгол Улс энийг үүсгэн байгуулагчийнх нь ... дээр орж ...сан асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж байж шийдвэр гаргуулсан. Мөн энэ талаар бас Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд бас танилцуулж холбогдох шийдвэрийг авсан байгаа.

Г.Тэмүүлэн: Асуултад гүйцээж хариулъя 7 номер Бямбасүрэн.

Г.Бямбасүрэн: Зурагдсан баримт бичиг одоогийн байдлаар Гадаад харилцааны яаманд хадгалагдаж байгаа. Энийг бол бид нар танилцуулах бүрэн боломжтой. Та бүхэнд танилцуулъя.

Г.Тэмүүлэн: Тулга гишүүн боссон уу? 9 номер Төрийн нарийн бичгийн дарга Мөнхтүшиг дарга.

Л.Мөнхтүшиг: Тулга гишүүний асуултад хариулъя. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхтүшиг. Виза бондтой холбоотой асуудлаар Гадаад харилцааны яам төлөвлөгөө гаргаад Гадаад харилцаа сайдаар батлуулаад ажиллаж байгаа нэгдүгээрт. Тэгэхээр 38 улсыг анх өнгөрсөн 8 сараас хойш оруулчихсан байгаад өнгөрсөн сард 3 дугаар сарын 18-нд Монгол Улсыг 12 улсын хамт нэмээд 50 улсын нэг болгосон. Энэ даруй бид нар Америкийн Элчин сайдын яамыг дуудаж байр сууриа илэрхийлж байгаа. Сая Тулга гишүүний хэлсэн асуудалтай холбоотойгоор хоёр талын тохиролцооноос нэг тал нь ингээд дангаараа гарчихаар 2001 оны тохиролцоо л доо тэр Монгол Улсын иргэдэд 10 жилийн виз олгох. Тэгэхээр энэ асуудлыг бид нар консулын шугамаар ярилцах саналаа тавьчихсан байгаа. Энэ үеэрээ бид бас визийн бондтой холбоотой

асуудлаар Монголын тал ямар шат дараатай арга хэмжээ хийх саналаа бас танилцуулах гэж байгаа. Тэгээд 8 сард “review” хийх юм.

Г.Тэмүүлэн: Тулга гишүүн нэмж тодруулъя.

Б.Тулга: Тийм, тэгэхлээр сая Бямбасүрэн даргад яахад тэр Байнгын хорооны даргад бас Байнгын хорооны ажлын албанд хэлэхэд бол Энхийн зөвлөл гээд байгаа тээ? Энхийн зөвлөл Трампын тэр Энхийн зөвлөлийн мэдээллийг дэлгэрэнгүй албан ёсоор сонсохыг хүсэж байна. Энэ дээр нөгөө шат шатын гаргасан Засгийн газар, Аюулгүй байдлын зөвлөлийн гаргасан бас шийдвэр, тогтоолуудтай энэ Байнгын хорооны гишүүд танилцах нь зөв байх гэж ийм бодолтой байна. Зүгээр яах вэ тэр дүрмийг бол интернэтээс олж үзсэн.

Тэгэхлээр тэр дүрэм бол бас яг тэр хувь улс төрчийн гэдэг юм уу Америкийн Ерөнхийлөгчийн хувийн компани гэж бараг ойлгогдож болохуйц сонин байгууллага байна лээ. Тэгэхлээр энэ дээр бас манайхан өөрсдөө очоод ялангуяа тэр дэлхийн бүх бараг улс шахуу цуглачихсан байгаа Давос дээр очоод гарын үсэг зурсан нь жоохон тийм ойлгомжгүй байдал төрүүлж байсан гэдгийг нэгдүгээрт хэлмээр байна.

Виз дээр бол та бүхэн бас хэлж байх шиг байна тэр төлөвлөгөөгөө гаргаад явах юм байна. Ер нь бол Америкчууд 10 жилийн виз визний хөтөлбөр харилцан хоёр талтайгаа тохирдог юм байна лээ шүү дээ. Тэгэхлээр энэ дээр бас та бүхэн.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Тулга гишүүний асуултад хариулъя. Санал уу? Наранбаяр гишүүн асуулт асууя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр өнөөдөр энэ олон туйлтай болчихоод байгаа гадаад харилцааны энэ хүнд хэцүү нөхцөлд Монгол Улсын гадаад бодлого олон тулгуурт, олон баганад энэ бодлого дээрээ тууштай байхад миний бие сэтгэл хангалуун байдаг. Ер нь Гадаад харилцааны яам нэлээн мэргэжлийн шинжтэй сайн ажиллаж байна гэж боддог. Яах вэ энэ тайланг нэлээн нарийвчилж уншлаа. 3 асуулт байна.

Нэгдүгээрт, энэ Монгол, Японы хооронд энэ нийгмийн даатгалын хэлэлцээрийг, нийгмийн халамжийн хэлэлцээр гэж ярьдаг юм байна лээ. Энийг одоо хүртэл байгуулаагүй байгаа. Тэнд чинь 20-иод мянган Монгол хүн ажиллаж, амьдарч, сурч байгаа. Тэгэхээр энэ асуудлыг бас Гадаад харилцааны яам хэр анхаарч байгаа вэ? Хөдөлмөрийн яамнаас асуухад энэ тал дээр эхлээгүй гэсэн юм ярьж байсан.

Хоёрт нь энэ өнөөдөр энэ Ормузын хоолойг боож хаачаад Иранаас гадна Америк өөрөө хаагаад эхэллээ шүү дээ. Тэгээд энэ урьд өмнө байж байгаагүй ийм олон улсын гэрээ эрх зүй, ялангуяа далайн эрх зүйг зөрчсөн ийм үйлдлүүдийг гаргаад байна. Энэ нь өөрөө дэлхийн эдийн засагт нөлөөлж байна. Монгол Улсад мэдээж нөлөөлнө. Үнийн өсөлтийг авчирна. Түүний зэрэгцээ энэ аялал жуулчлалд энэ онцгой нөлөөлөхөөр байна. Аялал жуулчлал өнөөдөр нэлээн ялангуяа тэр бөмбөрцгийн баруун хэсгээс ирэх энэ жуулчид нөлөөлөхөөр байна, үнэд нь нөлөөлж байна. Энэ тал дээр бас Гадаад харилцааны яам ямар хариу арга хэмжээ авахаар төлөвлөж байна вэ?

Гуравдугаар асуулт энэ ноднин 7 сарын 4-6-ны хооронд Улаан-Үүдэд бас энэ Боловсролын сайд нар Оросын Холбооны Улсын Дээд боловсрол, Шинжлэх ухааны сайд, Монгол Улсын Боловсролын сайд нар уулзаж мөн ийм ажлын уулзалт хийснээс гадна тэнд анх удаа ректоруудын уулзалт гэдгийг хоёр улсын их, дээд сургуулийн ректорууд цуглаж уулзсан юм. Цаад талаас 54 их сургууль, Москвагийн их сургууль толгойлж ирсэн. 54 их сургуулийн төлөөлөгчид ирсэн. 60 гаран төрөл 63 байдаг.

Монгол талаас 12 их, дээд сургуулийн нийтдээ мөн 50 орчим төлөөлөгч очиж ингэж тэнд уулзалт хийгээд хамгийн гол нь энэ чинь нөгөө Монгол Оросын Засгийн газар хоорондын Комиссын 26 дугаар хуралдааны дагуу явж байгаа ийм ажил. Энэ маш амжилттай болоод ирэх 25-аас 29 онд хоёр улсын хооронд дээд боловсролын хүрээнд шинжлэх ухааны хүрээнд хамтран ажиллах тухай яамд хоорондын ийм гэрээ, гарын үсэг зурагдсан байдаг юм. Мөн Оросын Холбооны Улсад суралцаж байгаа Монгол оюутнуудын тэтгэлгийг нэмэх талаар санал солилцсон. Мөн Оросын Холбооны Улс болон Монгол Улсын хоорондын боловсролын чиглэлээр хамтран ажиллах ихээхэн ийм үр дүнтэй ийм санал солилцох ийм уулзалтууд болсон. Энэ талаар Монгол, Оросын энэ харилцааны хэсэгт нь ороогүй дурдаагүй байна. Энэ ямар учиртай вэ гээд?

Г.Тэмүүлэн: Наранбаяр гишүүний асуултад хариульъя Батцэцэг сайд.

Б.Батцэцэг: Нэгдүгээрт нь энэ нийгмийн хамгааллын хэлэлцээрийг бид нар олон оронтой байгуулах гэж энэ саналаа тавьдаг. Тэгээд нэлээн ийм үр дүнтэй бас хэлэлцээрүүд болсон. Одоогийн байдлаар Оросын Холбооны Улс, Унгар, БНСУ, Польш, Турк, Чех улстай тус нийгмийн хамгааллын салбарт хамтарч ажиллах энэ хэлэлцээрийг байгуулсан. Мөн Казахстантай бас энэ тэтгэврийн хэлэлцээр байгуулахаар ажиллаж байгаа. Австрали улстай бас ажиллаж байгаа. Австрали, Казахстан 2 нэлээн сүүлийн шатад орсон байгаа. Швед, Япон, Австри, Канад, Америкийн Нэгдсэн Улстай нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах хүсэлтээ бол айлын талд байнга тавьдаг.

Япон Улсын хувьд болохоор харилцан адил байх зарчмыг баримталдаг учраас Монголд Япон иргэд ажил хийж байгаа Япон иргэдийн тоо маш цөөхөн байдагтай уялдуулж бас энэ дээр нэлээн ийм удаашралтай явж байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Орос, Монгол их, дээд сургуулиудын ректоруудын уулзалтын асуудлыг бол яах вэ энэ их ач холбогдолтой олон, хоёр талаасаа олон их, дээд сургуулиудын хамтын ажиллагааны баримт бичгүүд зурагдаж энэ ажил бол үргэлжлүүлээд Монголд болох гэж байгаа. Тэгэхээр энэ асуудлыг бид нар цаашдаа энэ хоёр орны харилцааны бас нэг чухал боловсролын салбарын хамтын ажиллагаа дээр бас илүү чухалчилж оруулж явъя гэдэг таны саналтай санал нэг байна.

Дараачийнх нь юу байлаа? Ормузын хоолойтой. Мэдээж энэ дэлхий даяар ойлгомжгүй байдал хэзээ яаж үргэлжлэх, хэзээ дуусах нь тодорхойгүй учраас бүхий л улс орнуудад адилхан л ийм сорилтод бид нар тулгарч байгаа. Мэдээж энэ аялал жуулчлал дээр асар их нөлөөлнө. Одоогоор энэ шатахуун, бензиний үнийн өсөлт, эрчим хүчний өсөлттэй холбоотойгоор онгоцны билет өсөөд эхэлчихсэн.

Тэгээд мэдээж манай аялал жуулчлалд тодорхой хэмжээгээр нөлөөлнө. Энэ нөлөөллийн эрсдэлийг бууруулах тал дээр Засгийн газар дээр бас холбогдох яамнууд нь тодорхой ажлуудыг төлөвлөөд ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Наранбаяр гишүүн нэмж тодруулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Би тодруулаад саналаа хэлчихье. Энэ бол боловсролын салбарт энэ хоёр улсын Оросын Холбооны Улс, Монгол Улсын хоорондын энэ хамтын ажиллагааг энэ тайландаа оруулж өгч байгаад юуны түрүүнд талархал илэрхийлье.

Хоёрдугаарт, энэ жил бас энэ ректоруудынх нь уулзалт 6 сарын сүүлээр, эсвэл 7 сарын эхээр Монгол Улсад болно. Олон хоёр талын хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрүүд их сургуулиуд хооронд бас, ялангуяа судалгааны салбарт нэлээн зурагдаж байгаа. Тэнд очиж зурагдсан, энд бас зурагдана. Ийм ач холбогдолтой ийм хамтын ажиллагааны ийм гэрээ хэлэлцээрүүд зурагддаг ийм Оросын Холбооны Улстай боловсролын чиглэлээр ажиллаж байгаа чухал зүйл ээ гэдгийг дахин тэмдэглэе хэлье.

Тэр аялал жуулчлалын тал дээр та бүхэн маань бас сайн судалж энэ аялал жуулчлалын холбоотой ярилцаж, мэргэжлийн холбоотой нь бас ярилцаж энэ асуудлыг тодруулж хариу арга хэмжээгээ эртхэн эхлүүлэхийг бас хүсэж байна. Яагаад гэвэл энэ яг одоо бензин юутай холбоотойгоор эхэлчихсэн үнийн өсөлт. Үнийн өсөлт нь эхэлчихсэн байгаа. Тэгээд түүнээс гадна энд жил ирэх жуулчны тоонд маш их санаа зовж байна. Яагаад гэвэл энэ аялал жуулчлал чинь жилээс жилд жуулчны тоогоо нэмж байгаа. Тэр дотроо хамгийн чанарлаг жуулчид ирдэг энэ чиглэл рүүгээ бид бас анхаарч явахгүй бол гадаад бодлогын манай үзвэр бол ер нь гадаад валютыг хэрхэн нэмэх, хөрөнгө оруулалтыг хэрхэн нэмэх энэ чиглэл рүү бас нэлээн хүчтэй явах учраас энэ тал дээр бас мэргэжлийн бас байгууллагын хувьд Гадаад харилцааны яам онцгой анхаараасай гэж хүсэж байгаа.

Түүний зэрэгцээ бас энэ гадагшийгаа Монголын компаниуд, ялангуяа Киргиз рүү 10 компани хөрөнгө оруулаад тэнд маш амжилттай ажиллаж байгаа юм байна лээ. Ийм зүйлүүдийг бас танай тайлан дээр бас нэлээн дурдсан байсан.

Цаашдаа ийм зүйлүүдийг ялангуяа Элчин сайд нарыг томилохдоо ер нь тэгээд нэг ярьдаг даа транзисторын наймаачин гэдэг шиг л ер нь Монголын бараа, бүтээгдэхүүнийг гадагш нь борлуулах ийм л үйлчилгээг гадагш нь гаргах ийм л чиглэл рүү илүү сайн анхаарч ажиллаасай гэж хүсэж байгаа. Мөн иргэдийнхээ дуу хоолой болж ажил.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Санал хэллээ гэж ойлголоо. Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Д.Цогтбаатар: Би гялс гялс асуугаад явчихна энэ тайланг нэлээн уншлаа. Тэгээд энэ ёслолын тэмдэглэл юм уу, хроник шиг л тиймэрхүү юм болчихсон л надаа харагдаж байна. Би дипломат үйл ажиллагааны технологитой холбоотой л юм эхлээд асуугаадахъя. Үгүй ээ энэ хроник тайлан, лавлах танилцуулгын хоорондын ялгаа юу вэ сайдаа?

Г.Тэмүүлэн: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Батцэцэг сайд.

Б.Батцэцэг: Байнгын хороон дээр 25 оны гол хийсэн ажлын тайланг тавь гэсэн. Товчхон тайлан тавьсан. Дэлгэрэнгүйг нь явуулсан байгаа. Хроник гаргаагүй. Хроникийг танд явуулаагүй байгаа.

Г.Тэмүүлэн: 7 номер уу? Хэн хариулах вэ? Цогтбаатар гишүүн нэмж тодруулъя. Болноо Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Тэгэхлээр энэ дипломат ажиллагааны хамгийн энгийн технологийн асуудал асууж байгаа байхгүй юу? Тэгэхлээр би өөрийн эрхгүй энэ дипломат нот чинь хэдэн төрлийн байдаг юм бэ?

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Батцэцэг сайд. Асуултад хариулъя албан ёсоор. Гишүүд, Цогтбаатар гишүүн асуулт асууя та гүйцээгээд.

Д.Цогтбаатар: Дараагийн асуулт дараагийн асуулт. Энд ингээд заачихсан байна л даа энэ тайлан дээр. Ингэснээр Монгол Улс НҮБ-ын гишүүн бүх 192 улстай дипломат харилцаа тогтоох зорилт бүрэн хэрэгжив ээ гэж байна. Энэ зорилт хаана тавигдсан ямар зорилт байдаг юм, хэлбэржиж яг тавигдсан?

Г.Тэмүүлэн: Асуултад хэн хариулах уу? 7 номер.

Г.Бямбасүрэн: Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал Бямбасүрэн асуултад хариулъя. НҮБ-ын бүх гишүүн улсуудтай дипломат харилцаа тогтооно гэдэг зорилтыг 2015 онд Монгол Улсын Ерөнхийлөгч дэвшүүлсэн. Тийм зорилтыг би Гадаад харилцааны яаманд өгсөн чиглэлийн дагуу хэрэгжүүлсэн. 11 жилийн дараа энэ бүх зорилт хэрэгжиж дууссан байгаа.

Г.Тэмүүлэн: Цогтбаатар гишүүн асуултаа.

Д.Цогтбаатар: Ийм зорилт гадаад бодлогын хаана ч ямар ч бичиг баримтад байхгүй. Энэ зорилтыг би өөрөө Сүхболд сайдыг байхад 3 улс үлдсэн байсан учраас наадхаа гүйцээгээд хийчих гэсэн. Яагаад гэвэл олон улсын эрх зүйн үр дагаваргүй ийм юмыг зорилт гэж тавина гэдэг аягүй аюултай байхгүй юу. Манай улс хүлээн зөвшөөрөхгүй орон НҮБ-ын гишүүн болох тохиолдолд бид нар бүх оронтой дипломат харилцаатай болно гээд зорилт тавиад явж байх уу? Энэ чинь манай 2 хөрш орон НҮБ-ын бүх оронтой дипломат харилцаатай биш байхгүй юу. Тэгэхлээр манайд харин зөрчилгүй байгаа учраас энэ удаад нь гүйцээгээд хийчих ээ гэдэг үүрэг даалгаврыг би тухайн үедээ Сүхболдод өгөөд явж байсан. Тийм учраас би тэр зорилго гэдэг чинь эрх зүйн үр дагавартай аягүй нарийн асуудал байхгүй юу.

Дараагийн асуулт энэ Япон, Монголын харилцааны юун дээр энэ ингээд биччихсэн байна л даа “алтан үсгээр бичигдэх жил болжээ” гээд энэ чинь парламентын засаглалтай орон шүү дээ. Энэ аягүй том айлчлал. Би ханхүүг үе залгамжлах ханхүү байхад нь айлчлалыг нь би өөрөө хийгээд зохион байгуулаад явж байсан. Парламентын засаглалтай орны хаан айлчлал нь энэ том амжилт. Би энийг ерөөсөө үгүйсгэхгүй. Гэхдээ энд “алтан үс үсгээр” бичигдэнэ гэхлээр чинь бусад орны төрийн тэргүүнүүд, 2 хөршийн төрийн тэргүүн, АНУ-ын төрийн тэргүүн эд нарыг ирэхэд Гадаад яам хэзээ ч ингэж “алтан үсгээр тэмдэглэнэ барина” гэж ярьж байгаагүй. Би тэгээд энэ дээр юм асуучихъя “sovereign equality” гэж юуг хэлдэг юм бэ? Хаана эх сурвалж нь бичигдсэн байдаг юм бэ?

Г.Тэмүүлэн: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Асуултад хариулъя 7 номер.

Г.Бямбасүрэн: Тайлан дээр “алтан үсгээр бичсэн” гэдэг бичсэн хүнийхээ хувьд би бас алдаа гаргасан гэдгийг хүлээн зөвшөөрье. “Sovereign equality” гэдгийн талаар яг тодорхой би мэдээлэл өгч мэдэхгүй байна.

Г.Тэмүүлэн: Таны минут дөхөж байгаа Цогтбаатар гишүүн. Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Энэ НҮБ-ын олон улсын, НҮБ-ын дүрэмд 2.1.1-д заачихсан байгаа Олон улсын хуулийн хамгийн суурь зарчим. Тэгэхлээр өөр улсын төрийн тэргүүнүүд ирсэн байхад бид нар ингэж дүгнээгүй байж өөр нэг улсын төрийн тэргүүнийг ирэхэд ингэж дүгнэж байгаа чинь эндээ тэр “sovereign equality” бүгдэд нь жигд хандах энэ зарчим чинь өөрөө алдагдаж байгаа байхгүй юу. Тийм учраас хэзээ ч Гадаад яаманд ингэж дүгнэж бичиж байгаагүй юм. Тэгээд би энийг асууж байгаа юм.

Гурав дахь асуулт нь тэгвэл энэ Гадаад яаман дээр Хүний эрхийн нэгжийг яагаад татан буулгачихсан юм бэ? Энийг байгуулах эх сурвалж нь юу юм бэ?

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя 7 номер Бямбасүрэн.

Г.Бямбасүрэн: 2025 онд шинээр байгуулагдсан Засгийн газраас бол газар нэгжийг багасга гэдэг чиглэл авсан. Энэ утгаараа Хүний эрхийн хэлтэс гэдгийг нэрээр нь байхгүй ч гэсэн Олон улсын гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газарт ажил үүргийн хуваарийн дагуу хариуцаад ажиллаж байгаа. Үргэлжлүүлээд ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Сүүлийн минут байгаа. Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Энэ Хүний эрхийн нэгжийг Монгол Улсад олон улсын хэм хэмжээ хүний эрхийн юуг 2008 оны 7 сарын 1-ний дараа гарсан энэ эмгэнэлт тохиолдлоос болж Гадаад яам энийг оруулж ирж Монголд нутагшуулахад үнэхээр анхаарч ажиллах тэргүүний туршлагыг нь Гадаад яаманд байна гээд байгуулж байсан юм. Одоо та нар Хүний эрхийн дээд комиссарыг энд авчрах гэж байна. Тэд нартаа юу гэж хэлэх гэж байна? Ийм нэгжийг нь татан буулгачихсан. Эх сурвалж нь НҮБ-ын дүрмийн чинь 1 дүгээр зүйл, 55 дугаар зүйл, 76 дээр, манай гадаад бодлогын үзэл баримтлал дээр чинь бүгд суучихсан байж байгаа. Энийг Гадаад яам хийж байх ёстой байхгүй юу. Тэгээд би энийг харамсаж байгаа юм. Та нар энийгээ татан буулгачихсан. Тэр тайландаа энийгээ оруулаагүй байгаа байхгүй юу. Тэгээд юу татан буулгаж байгаагаа манай гадаад бодлогын яг нэлээн давамгайлж ажиллаж байгаа тэр гадаад бодлогын үзэл баримтлалд 11 онд өөрөө би хэлэлцэж байсан хүн нь байж байна л даа. Энийгээ оруулаагүй байгаа чинь бид нарын хувьд бас эргээд олон түмэнтэй ярьж байхад гадаад бодлогынхоо тунхагласан зорилтоос ухарчихсан байгаа ийм л асуудал гараад байгаа юм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Санал хэллээ. Болормаа гишүүн асуулт асууя.

Э.Болормаа: Гадаад харилцааны яамны энэ тайлан дээр 2 хөршийн буюу Монгол, Хятадын харилцаа дотор ийм зүйл орсон байна л даа. Бүгд Найрамдах Хятад Ард Улсад Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2 дугаар сарын 14-нөөс 15-ны

өдөр Харбин хотноо болсон 9 дэх удаагийн Азийн өвлийн наадмын хаалтын ажиллагаанд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Төрийн зөвлөлийн ерөнхий сайд Ли Чаны урилгаар оролцов. Мөн Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 5 дугаар сарын 14-нд Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганц мод хил дамнасан төмөр замын шав тавих ёслолд оролцов гэж. Энэ бидний яриад байгаа Харбины гэрээ. Яг манай энэ Байнгын хороо энэ Харбины гэрээг дэмжих шийдвэрийг бид нар хамтдаа гаргаж байсан. Тэр үед Батцэцэг сайд та, Туваан сайд, Дэлгэрсайхан сайд гээд энэ дээр голлож ажиллаж байсан хүмүүс хэрвээ би буруу санаагүй бол Харбины гэрээг үзэглэхэд та мөн хамт Харбинд айлчилж байсан байх. Та айлчлаагүй байх. Өнгөрсөн 7 хоног мэдээж парламентын ардчилалтай улс учир нээлттэй бид нар асуудлуудаа хэлэлцдэг. Сөрөг хүчний зүгээс энэ хэрэгжээд 2 жил ч хүрээгүй байгаа энэ хэлэлцээрийг Хянан шалгах түр хороо байгуулъя гэдэг санаачилга гаргаад санал хураалт явагдахад үүн дээр Гадаад хэргийн сайд та Хянан шалгах түр хороо хийх нь зөв гэж ийм санал өгсөн байсан.

Зам, тээврийн сайд бол албан ёсоор мэдэгдэхдээ хэрвээ Монгол Улсын тал энэ сонсголыг хийх юм бол Хятадын тал боомтоо хаана, нүүрс худалдан авалт зогсоно гэдэг ийм бас нэлээн ноцтой мэдэгдлийг хийсэн. Тэгэхээр та энэ санал хураалтыг би магадгүй алдаатай өгсөн болов уу саналаа тэгж өгсөн болов уу гэж бодож байна. Тэгэхээр Гадаад харилцааны сайдын хувьд энэ манай Монгол Улсын гадаад бодлогын нэг цонхны бодлогод ийм бодлоготой байгаа юм уу? Та өөрөө ажиллаж байсан Засгийн газартаа энэ гэрээ хэлэлцээрийг зурахад Гадаад харилцааны сайдын хувьд оролцсон. Яг юу өөрчлөгдөөд ийм байр суурьтай болсон бэ? Танд бас нэлээд олон хүн энэ салбарыг анхаарч ажигладаг хүмүүс энийг асууж байгаа, манай 2 талын хөрш бас энийг нэлээн анхаарч байгаа учир би танд энэ дээр бас хариулт хэлэх боломж өгөх нь зүйтэй болов уу гэж таны байр суурийг асуух гэсэн юм.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүний асуултад хариулъя Батцэцэг сайд.

Б.Батцэцэг: Байнгын хорооны дарга надад энэ Цогтбаатар сайдын хандлага ерөөсөө таалагдахгүй байгаа. Өөрөө сайд байсан байж байж байнга ийм сонин сонин үйлдэл гаргадаг. Би асуултад хариулахаас татгалзаж байгаа шүү. Цаашдаа ч гэсэн би татгалзана.

Болормаа гишүүний хувьд маш буруу ойлголттой байна. Нэгдүгээрт би эсрэг санал өгөөгүй. Хоёрдугаарт тэр гэрээнд Засгийн газрынхаа нэгдмэл байдлыг хангаад кабинетынхаа зарчмыг бариад өнөөдрийг хүртэл дэмжээд явж байгаа. Энэ гэрээг байгуулахад нь оролцсон. Манай яам орчуулгад нь оролцсон. Уулзалт, арга хэмжээг зохион байгуулахыг мэдээж зохион байгуулсан. Одоо хүртэл тэр байр сууриндаа хэвээрээ байгаа гэдгийг хэлье. Тэгээгүй байсан бол би наад дээр чинь тайлан дээр оруулах ч үгүй.

Тэгэхээр тайлан дээр үнэн, бодитой хийсэн ажлууд бүгд дурдагдаад явж байгаа. Манай хоёр орны харилцаанд ч гэсэн наадах чинь өөрөө чухал үйл явдал болсон. Хил, гааль, боомтын хөгжилд ялт ч үгүй дэвшил авчирсан ийм гэрээ болсон гэдэг бодолтой хэвээрээ байгаа. Тэгэхээр та наад буруу ойлголтуудаа бас зассан нь зөв байх.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүн нэмж тодруулъя.

Э.Болормаа: Та Цогтбаатар сайдтай маргалдаад тэрнийхээ сэтгэл зүйн хөдлөлөө над дээр гаргаад байх шиг байна л даа. Би танд сая хэлж байна шүү дээ. Та битгий хэрэлдээд бай л даа. Би яг баримттай юм ярих гээд байна шүү дээ. Одоо олон нийтэд Гадаад харилцааны сайд энэ Хянан шалгах түр хороог хийх нь зөв өө гэдэг ийм буруу ойлголт байгаа. Та энэ дээрээ тайлбар тавих нь зүйтэй юм болов уу гэж би танд боломж олгох үүднээс хэлж байна шүү дээ. Та сая яг хэллээ шүү дээ би энийг Хянан шалгах түр хороо байгуулах нь буруу гэж та үзэж байна гэж хэлж байгааг зөв үү? Би тэгж ойлгох нь зөв үү? Үгүй ээ энэ та Улсын Их Хурлын тамгын газар санал хураалтын дүнг хараарай. Улсын Их Хурлын Тамгын газрын санал хураалтын дүн шүү. Тэрнээс биш би энд зохиож юм яриагүй байна шүү. Тэгэхээр энэ дээр би танд албан ёсоор магадгүй гараад явчихсан, эсвэл юу болсон юм энэ дээрээ тайлбараа хэлэх нь зүйтэй болов уу л гэдэг үүднээс ийм эергээр танд энэ боломжийг олгох нь зүйтэй гэж харж байгаа юм шүү.

Г.Тэмүүлэн: Би хэд хэдэн асуултуудыг асуугаадахъя. Гишүүд анхааралтай байгаарай. Бид хэд энэ угаасаа Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиар өмнө ажлаа шууд тайлагнадаг байгууллагын тайлан, мэдээллийг бол сонсох, хагас жил тутам сонсдог үүрэгтэй байсан маань 2024 оны Улсын Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хуулийн өөрчлөлтөөр бас байхгүй болчихсон зохицуулалт байгаа. Тэгэхээр угаасаа цаашдаа манай бусад Байнгын хороонууд ч гэсэн яг ажлаа шууд тайлагнадаг байгууллагуудын мэдээллүүдийг жилдээ 1 удаа заавал сонсох шаардлагатай байна гэж үзээд байгаа. Тэгээд энэ 7 хоногт манайх Гадаад харилцааны яамны мэдээллийг ингээд сонсож байна. Дараа 7 хоногт Батлан хамгаалахын яам бол бас холбогдох мэдээлэл, танилцуулгуудаа хийхээр орж ирж байгаа.

Тэгэхээр үндсэндээ манай Гадаад харилцааны яам өөрөө тусгай чиг үүрэгтэй ийм яам. Тэгээд улс орны суурийн нэн тэргүүний бодлого нь өөрөө бас гадаад бодлого нь өөрөө байдаг. Тэгээд энэ хүрээнд бид нар бас тодорхой энэ олон улсын нөхцөл байдал өөрөө хүндэрч байгаа тодорхой ямар алдаа гаргах эрх байхгүй энэ цаг үе дээр бас адармаатай үл ойлголцол, геополитикийн тавцанд хүндэрч байгаа энэ цаг үе дээр бол бид нар бас илүү салбарын үйл ажиллагаа болоод, бодлогын талаар бол мэдээлэл авах, харилцан ойлголцох, мэдээлэл бас тодорхой хэмжээнд хүргэж байх ийм шаардлага байна гэж бас үзэж байгаа.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүд Гадаад яаман дээр бас өнгөрсөн жил ажилласан. Энэ хүрээнд тодорхой бид нар бас тодорхой энэ нөхцөл байдалтай уялдуулаад үндсэндээ юу гэдэг юм хүйтэн дайны үеийнх шиг ийм хуваагдал үүссэн байгаа энэ цаг үе дээр гадаад харилцааны хөрс суурь байхгүй болж байгаа яг ийм хариуцлагатай үе дээр бол бид нар тодорхой чиглэлүүдийг бол өгсөн. Энэ талаар манай Байнгын хорооны гишүүд тухайн үед бас Гадаад харилцааны яаман дээр ажиллаж байхад бол чиглэл болгож хэлсэн байгаа. Энэ талаар та бүхэн маань бас мэдээлэл өгөөч ээ гэж бол нэгд хэлэх гэсэн юм.

Нэгдүгээрт, бид нарын хувьд энэ үндсэндээ тулгарч байгаа энэ шинэ сорилт дээр, тулгарч байгаа энэ асуудлуудыг зөвөөр үнэлж зөв бодлого боловсруулж байх зайлшгүй шаардлагатай байгаа. Тэгэхээр нэгдүгээр асуудал бол үндсэндээ олон улсын харилцааны судалгааны институт ч гэсэн тогтолцоог, судалгааны механизмыг бол бий болгох шаардлагатай байна гэж үзсэн.

Энэ хүрээндээ өмнө нь бид нар бас хэлэхдээ бол Гадаад харилцааны яаман дээр судалгаа, шинжилгээний процессыг эрчимжүүлэх буюу дэргэдээ бол судалгааны хүрээлэн, төв байгуулах үүрэг чиглэлийг бол болгосон байгаад байгаа. Энэ ажил ер нь яг ямар түвшинд явж байгаа бол? Өнгөрсөн онд бид бүхэн тодорхой бас энэ төсөв батлах үед бас энэ асуудлыг бас нягталж магадалж байсан. Энэ жилээс энэ бас ажил бол бодит ажил хэрэг болох ёстой гэж бол харж байгаа.

Хоёрдугаарх нь одоогоос үндсэндээ 15 жилийн өмнө батлагдсан байгаа гадаад бодлогынхоо үзэл баримтлал болоод энэ, минутыг нь нэмээд өгөөрэй. Үзэл баримтлалынхаа хэрэгжилтээ дүгнэж цэгнэж харах зайлшгүй шаардлагатай байна гэж хараад байгаа юм. Тэгэхээр үндсэндээ өнөөгийн яг энэ шинэ тэнцвэрийн үе дээр бол бид нар энэ гадаад бодлогынхоо үзэл баримтлалаа илүү тодотгох шинэчлэх шаардлагатай байна гэж үзээд үзэл баримтлалаа шинэчлэн оруулж ирэх энэ үүрэг, даалгаврыг бас Гадаад харилцааны яаманд бол өгч байсан. Дипломат албаны тухай хууль дээр бас өөрчлөлт оруулах асуудлыг бас хөндөж гаргаж ирж тавьсан. Гадаад харилцааны тухай хуультай болох нь зүйтэй юм уу гэсэн саналыг бол бас манай Байнгын хорооны гишүүд гаргаж ирж тавьж байсан. Энэ ажил яг ямар түвшинд явж байгаа гэдэг асуудлыг бас гаргах гэж байна.

Гурав дахь нь үндсэндээ олон улсын харилцааны энэ хүний нөөцийн бодлогын асуудлаар бид нар анхаарах, яг мэргэжилтэн бэлтгэдэг институц, сургуулиудаа бэхжүүлэхэд бас анхаарах, болж өгвөл яам бол дэргэдээ бас Дипломатын академи байгуулан ажиллах боломжийг судалж үзээч ээ гэдэг асуудлыг бол бас гаргаж ирж тавьж байсан. Энэ хүрээнд яг ямар бодлого шаардах ажил явж байгаа бол? Үндсэндээ бид нар үндсэндээ энэ гадаадуудын шийдвэр гаргах механизмаа л зөв болгох, илүү бас хариуцлагатай болгох, илүү бас шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаанд суурилсан ийм бодлого гаргадаг байх, тинк танк судалгааны хүрээлэн хөгжүүлэлтийг бас хөгжүүлэх шаардлагатай байна гэж бол бас үзэж, илүү гадаад бодлогыг эрдэмжүүлэх шаардлагатай байна гэж үзэж бол ингэж ингэсэн. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань бас ямар түвшинд ажил явж байна энэ талаар мэдээлэл өгөөч гэх гэсэн юм.

Г.Тэмүүлэн: Батцэцэг сайд.

Б.Батцэцэг: Байнгын хорооны гишүүд өнгөрсөн жил ажиллаад хэд хэдэн зүйлийг сая Байнгын хорооны даргын хэлснээр бид нар хийж хэрэгжүүлсэн.

Нэгдүгээрт нь бид нар Бодлого, төлөвлөлтийн газар дээрээ дүн шинжилгээний нэгж байгуулсан. Энэнтэй холбоотой бид нар бас олон, нэлээн хэдэн жил бас дээр үед хийж байсан дүн шинжилгээнүүд тасарчихсан, дүн шинжилгээ хийх мэргэжилтэй хүн боловсон хүчин бас дутагдалтай болсон байсан. Одоо бол ямар ч байсан 3 хүн энэ асуудлыг хариуцаад ... нүүдээс ирж байгаа мэдээлэл болон ил эх сурвалжууд дээр ямар ч байсан ийм дүн шинжилгээ хийдэг ийм нэгжтэй болсон. Ажиллаад явж байгаа. Тодорхой үр дүнгүүд гарч бас зохиох хүмүүстээ мэдээллийг хүргэж байгаа.

Хоёрдугаар асуудал нь энэ томилогдож байгаа Элчин сайд нарыг бэлтгэж явуулах асуудал байсан. Томилгоонд бас анхаарах, мэргэжлийн байх тал дээр нь бас зөвлөмж өгсөн. Энэ дээр бид нар Элчин сайд нарыг энэ жил нийтдээ 21 Элчин сайд томилогдож байгаа. 3 сарын хугацаанд бас бэлтгэл ажлыг нь хангаж, сургалтууд хийх, үйлдвэр, газруудыг үзэх, бүтээн байгуулалтуудтай танилцах,

хөдөө орон нутгийн аймгийн Засаг даргын Тамгын газруудтай ярьж хөдөө орон нутагт бас томилолтоор ажиллуулах, орон нутгийн ажил, амьдрал, малчин, тариаланчидтай танилцах, мөн хөдөө орон нутгийн гадаад харилцааг хөгжүүлэх чиглэлээр бас тодорхой дадлага туршлага орон нутагтаа бас боломжоор нь ингээд хамтраад ажиллаад Элчин сайд нараа нэлээн нарийн бэлтгэж явуулж байгаа.

Дипломатуудын томилгоо дээр ч гэсэн бид нар бас мэргэжлийн байх үүднээс нь давтан сургалт, гадаад, дотоодод бас богино хугацаанд сургалтуудад нэлээд ихээр нь хамруулж ж байгаа. Ингээд дипломат албаны томилгоог бас улс төрийн нөлөөгүй, гаднаас бас хүн явуулахгүй байх, мэргэжлийн байх тал дээр нь онцгой анхаарал гарч статистик гаргаж үзүүлэх юм нэлээн ахиц бас сүүлийн жилүүдэд гарсан байгаа гэдгийг хэлье.

Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах саналуудаа бид нар ярьсан. Дотроо бас ажлын хэсэг байгуулаад саналуудаа ерөнхийдөө бэлтгэсэн байгаа. Гадаад харилцааны тухай хуулийн төслийг бас 2 жилийн хугацаанд өмнө нь бас 14, 5, 6 онд тодорхой гишүүд бас энэ асуудлыг ярьж байгаад орхисон байдаг. Энэ хуулийн төслийг бид нар боловсруулаад манай яаман дээр бас ажлын хэсэг байгуулаад ажиллаж байгаа. Хамгийн сүүлийн төсөл дээр бид нар Мөнх-Оргил сайд гэх мэт хуучин сайд нараа татаж оруулаад мэргэжлийн хуульчдын багтай энэ асуудлаа яриад ер нь бол төслийг эцсийн байдлаар Засгийн газарт танилцуулахаар бэлдсэн байгаа.

Дипломат академийн хувьд бол хуучин манай бүтэц Дипломат академи байсан. Энийг харамсалтай нь бас нэлээн хэдэн жилийн өмнө ТББ болгож салгасан. Энд манай ахмад дипломатууд ТББ хэлбэртэй авч явж төлбөртэй үйлчилгээ үзүүлж бас төрийн байгууллагууд, хувийн хэвшлийнхэнд, орон нутгийн байгууллагуудад бас хичээл заах хэлбэрээр ажиллуулж байгаа. Бид нар бол яамандаа энийг хуучин бүтцэд нь авч Дипломат академийг байгуулж орон даяар орон нутаг болон төрийн байгууллагуудаас гадаад харилцааны ажилтан бэлтгэх, тэгээд өөрийнхөө дипломатуудыг давтан сургалт хийх яг утгаар нь ажиллах олон улсын түвшинд бас бусад улс орнууд Дипломат академитай байдаг улсуудтай аль түвшинд ажиллуулах энэ саналыг гаргаж байгаа.

Харамсалтай нь энэ жилийн хувьд бид нар авч чадаагүй. Төсөв мөнгөний байдалтай холбоотойгоор Дипломат академийг нөхөж байгуулж чадаагүй байгаа. Манайхан нэмэх юм байгаа юу? Төрийн нарийн бичгийн дарга 9 номер.

Г.Тэмүүлэн: 9 номер Мөнхтүшиг Төрийн нарийн бичгийн дарга.

Л.Мөнхтүшиг: Энэ хүний нөөцийн бодлого болон Дипломат академитай холбоотой асуудлаар нэмэлт тодруулга өгье Мөнхтүшиг. 2025 оны 6 дугаар сард зас Засгийн газар шинээр бүрдэхэд Дипломат академийг бас Гадаад харилцааны яамныхаа бодлогын газрын нэгжид оруулж ирсэн байгаа. Энэ бол дипломат сургалт гэдэг байдлаар дипломат сургалт, судалгаа, дүн шинжилгээний хэлтэс гэдэг байдлаар орж ирсэн. Харамсалтай нь төсвийн хэмнэлттэй холбоотойгоор орон тоо бас тодорхой хэмжээгээр царцаасан. Энэ хүрээндээ бид нар цаашдаа энэ активыгаа илүү хүн хүчийг нь бэхжүүлэх боломж одоогоор хомс байгаа. Цаашдаа энийг бид нар хөгжүүлээд явах бүрэн боломжтой байгаа.

Түрүүн тэр үзэл баримтлалтай холбоотой асуудлаар товчхон мэдээлэл өгөхөд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс нөгөө үндэсний аюулгүй байдлын

үзэл баримтлалыг шинэчлэх асуудал явж байгаа учраас энэтэйгээ уялдаад гадаад бодлогын үзэл баримтлалын асуудлыг хамтад нь явуулах нь зүйтэй гэдэг зүйлийг Гадаад харилцааны яам дотроо бас ярилцсан байгаа.

Г.Тэмүүлэн: Сая гишүүдээс гарсан бас асуудлууд дээр нэг зүйлийг бас онцолж тодруулж асуухгүй болохгүй болж байна. Сая АНУ-ын Ерөнхийлөгчийн Трампын санаачилсан Энхийн зөвлөлийн асуудал байгаа. Тэгэхээр сая сайдаас өгсөн мэдээллээр бол шийдвэр гаргах процесс Засгийн газар дээр болоод Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр танилцуулагдаад ингээд бол энэ Энхийн зөвлөлийн дүрэмд нэгтгэх энэ шийдвэр бол гарсан байна гэж бол ойлголоо. Тэгэхээр энэ шийдвэр гарах процесстой холбоотойгоор мэдээллүүдийг Байнгын хорооны гишүүдэд бас өгөөрэй гэдэг зүйлийг нэгдүгээрт бас хэлэх байна.

Энэ Энхийн зөвлөлд элсэх үндэслэл, шалтгаан маань өөрөө яг юу болсон юм бэ? Үндсэндээ бид нар энэ асуудлыг авч үзэхэд тухайн үед бол Байнгын хорооны гишүүд бол энэ Энхийн зөвлөлийн дүрэмд нэгдсэний дараагаар бол хэвлэл мэдээллээс мэдээллийг аваад ингээд Гадаад яам руу харилцаад тодорхой та бүхнээс ирүүлсэн ерөнхий мэдээллүүдийг бол авсан байгаа. Эндээс одоогийн байдлаар гээд аваад үзэхэд би буруу мэдээлэл бас шинэчлэгдээгүй байж магадгүй. Энэ Энхийн зөвлөлийн дүрэмд нэгдэхгүй боловч зарчмын хувьд дэмжиж ажиглагчаар оролцож байгаа гээд улс орнууд бас нэлээн байгаа. Британи, Франц, Австри, Герман, Солонгос, Австрали, Япон, Шинэ Зеланд, Польш, Нидерланд, Япон ч гэдэг юм уу.

Тэгэхээр бид бүхний хувьд үндсэн уг нь бол мэдээж зарчмын хувьд бол энхийн замаар шийдвэрлэхийг бол тууштай дэмжиж байгаа манай улс. Энэ эвсэлд нэгдэх гэдэг юм уу энэ энхийн зөвлөлийн дүрэмд нэгдэх үндсэн үндэслэл, шалтгаан маань өөрөө яг юу байсан юм бэ? Уг нь бол Монгол Улсын аюулгүй байдлын үзэл баримтлалаар үндсэндээ Монгол Улс маань эвсэлд үл нэгдэх гэдэг бас бодлого ингэж баримталж явж байгаа. Тэгэхээр яагаад зайлшгүй элссэн юм бэ? Тэр дундаа нэг улсын төрийн тэргүүний санаачилсан ийм зөвлөл болоод ийм байгууллагад нэгдэж нийлэх зайлшгүй шаардлага үүссэн юм уу? Энэ асуудал өөрөө Монгол Улсын гадаад бодлогын хувьд яг ямар зарчмын хүрээнд одоо та хэд маань бас энийг яг ер нь хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн бэ? Тэнцвэртэй гадаад бодлогыг хүчний тэнцвэрийг барих хүрээнд хийсэн юм уу, эсвэл олон хэмжээст гадаад бодлого болоод дипломат ажиллагаатай холбоотойгоор хийгдсэн ажил юм уу? Тэгэхээр тэр тодорхой мэдээллүүдээ өгч болох хэмжээнд нь та хэд өгөөд, шаардлагатай мэдээллүүдийг албан ёсоор гишүүдэд бас ирүүлэхийг бол хүсье.

7 номер Бямбасүрэн.

Г.Бямбасүрэн: Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал Бямбасүрэн гишүүний асуултад хариулья.

Энэ Энхийн зөвлөлийг байгуулах асуудал 2025 оны 12 дугаар сард НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 28-03 дугаар тогтоолоор гарсан тогтоолтой шууд холбоотой. Энэ дээр Газын мөргөлдөөнийг зогсоох цогц төлөвлөгөө болон Энхийн зөвлөлийг байгуулахыг дэмжсэн агуулгатай ийм тогтоол Аюулгүйн зөвлөлөөр батлагдсан. Үүний дагуу энэ АНУ-ын санаачилгаар энэ Энхийн зөвлөл гэдгээр байгуулсан. Үүний Энхийн зөвлөлийн дүрмийг бид нар судалж үзээд яахад Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал ялангуяа энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт зарчимд нийцэж байна гэдэг зүйлийг гаргасан. Үүнтэй

холбогдуулан бас дэлгэрэнгүй мэдээллийг бид нар Гадаад харилцааны яамны зүгээс бичгээр Байнгын хорооны гишүүдэд хүргүүлэх болно.

Г.Тэмүүлэн: Баярлалаа Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Мэдээлэлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу?

Болормаа гишүүнээр тасалъя. Цогтбаатар гишүүн үг хэлье.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Засгийн газраас асуулт асуух хэрэгтэй. Би заавал таалагдах асуулт, магтаал, дагаж намирсан элсэн асуулт асуух албагүй. Улсын Их Хурлын гишүүний асуусан асуултад хариулдаг байх ёстой. Би яг энэ өгсөн тайлангийнх нь хүрээнд асуулт асуусан. Энэ тайлан чинь хроник маягийн юм уу, эс үгүй бол ёслолын тэмдэглэл маягийн ийм болчихсон байна гээд л энэ мэргэжлийн цэвэр дипломат технологи үйл ажиллагааны технологийн хүрээнд асуулт асуусан. Тэгээд энэндээ би үгүй ээ дипломат ноот хэдэн төрөл байдгийг мэдэхгүй байна гэж яаж бодох юм бэ? Тийм. Тэгэхлээр энэ дээр Их Хурлын гишүүний асуулт асуугаад энд нь ямар нэгэн байдлаар дургүйцэх хэрэггүй. Энэ эрх чинь Үндсэн хуулиар бид нарт олгогдсон эрх байж байгаа. Тэгээд энэний хүрээнд би яах аргагүй цаанаа олон улсын эрх зүйн үр дагавартай ийм дүгнэлтүүд яваад байхлаар чинь сэтгэл зовсондоо л асууж хэлсэн.

Энэ дээр би ахиад нэг зүйлийг хэлэхэд энэ тайлан юмнууд дээрээ энэ дурдаж байгаа энэ дүгнэлт юмнуудаа бас мэргэжлийн түвшинд сайн хардаг байх хэрэгтэй. Яагаад гэвэл бусад орны хүмүүс ч гэсэн энэ дээр чинь ингээд ялгаварлан гадуурхчихсан ч юм уу ийм шинж чанартай юм байхад чинь хүмүүс асуулт асуугаад, бид нараас биш та нараас наадуул чинь асууна шүү дээ. Тэгэхлээр энэ дээр тэр хариултаа мэдэхгүй байгаа миний буруу биш шүү дээ. Би тэгээд л асуух ёстой юмаа л асуугаад ажлыг нь сайжруулах, засах үүднээс.

Нэг зүйл харин Тэмүүлэн даргаа хариулт гаргаж өгөөрэй. Би Гадаад бодлогын байнгын хороон дээр 2 дахиа байна уу 3 дахиа л асуулт асууж байгаа шүү. Та тоог нь гаргаад өгөөрэй. Тэгээд 2 удаа асуухад нэгд нь ч хариулаагүй тэрэнд би буруутай юу? Тэгэхлээр би энэ Байнгын хороон дээр асуулт асууж, үг хэлэх эрхтэй. Би тэрийгээ л хэрэгжүүлж байгаа юм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүн үг хэлье.

Э.Болормаа: Өнгөрсөн 7 хоногийн Харбины гэрээний түр сонсгол, түр хороо болон магадгүй холбогдох сонсголттой холбоотой яг санал хураалтын мэдээллийг би Улсын Их Хурлын Тамгын газраас татаж авлаа. Зөвшөөрсөн букуу энэ түр хороог байгуулах нь зүйтэй гэж идэвхтэй ногоон товч дарсан 5 Засгийн газрын сайд байна. Үүний нэг нь манай Гадаад харилцааны сайд байна. Тэгэхээр би энэ буруу ойлголт өгөх вий. Дээрээс нь би өөрөө бас Монгол, Хятадын парламентын бүлгийн дэд даргын хувьд энэ асуудал дээр Гадаад харилцааны яам нэлээн онцгой анхаарал хандуулах ёстой шүү. Монгол Улсын Их Хурал бол олонхоороо үүн дээр түр хороо байгуулах нь буруу гэж үзсэн. Бид үүнийг дэмжээгүй. Яагаад гэвэл бид өөрсдөө энэ гэрээг хийе гэж өмнө нь энэхүү Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоороо энэ зүйтэй гэж бид нар өөрсдөө хэлэлцээд шийдвэр гаргасан. Тэр шийдвэр дээрээ хатуу зогсож байгаа олонх нь. Тэгэхээр энэ 5 сайд өнөөдөр 2 нь бас энэ хурал дээр сууж байна. Засгийн газрын Хэрэг

эрхлэхийн сайд болон Гадаад харилцааны сайд нар энэ асуудал дээр онцгой анхаараарай гэж би хүсмээр байгаа юм.

Тэгэхээр ямар нэгэн алдаатай буруу ойлголт хөршдөө өгсөн байх бий. Энэ цаашлаад даамжраад Монгол Улсын эдийн засагт ноцтой үр дагавар гаргах вий дээ гэдэг энэ болгоомжлолын үүднээс Байнгын хорооныхоо гишүүнийхээ хувьд салбарын сайдад энэ асуудлыг хэлж байгаа юм шүү. Та бүхэн энийг бас зөв, зүйтэй ойлгож аваарай. Тэрнээс биш бид энд ямар явган хэрүүл хийх гээд суугаагүй шүү дээ. Хоёр орны хоорондох томоохон харилцааны асуудлыг ярьж байгаа учир Гадаад харилцааны сайд та, мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга та энэ асуудал дээр онцгой ач холбогдол өгч анхаараарай гэж хүсье.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүнд баярлалаа. Гишүүд мэдээлэлтэй холбогдуулаад үг хэлж дууслаа.

Би бас тодорхой саяын асуудлууд дээр бас саналаа хэлье. Тэгэхээр үндсэндээ нөхцөл байдал өөрөө бас ийм сайнгүй байгаа олон улсын ээдрээтэй тодорхойгүй өнөөгийн нөхцөл байдал дээр энэ нөхцөл байдал магадгүй олон жилийн хугацаанд ч ийм үргэлжлэх ийм эрсдэлтэй нөхцөл байдал бол үүссэн байна. Тэгэхээр бид бүхний хувьд ямар ч бай энэ тохиолдолд бас Монгол Улсын хувьд шинэ тэнцвэрийн үе дээр магадгүй энэ үндэсний аюулгүй байдал болоод гадаад бодлогынхоо үзэл баримтлалаа шинэчлэх цаг үе өөрөө бас ирж байна уу гэж бол бас хараад байгаа. Энэ ч үүднээсээ бас өмнөх, өмнө жил манай Байнгын хорооны гишүүд Гадаад харилцааны яаман дээр ажиллахдаа бол тодорхой үүрэг даалгаврын чиглэлүүдийг бол өгсөн. Тэгэхээр энэ гадаад харилцааныхаа хууль, эрх зүйн орчныг сайжруулах дээр бол анхаарч ажиллаарай. Энийг бол дахиад тодорхой чиглэлийг бол бас болгож байна Байнгын хорооноос.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал бол 2011 онд батлагдаж байсан. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2015 онд бас тус тус батлагдсан байгаа. Тэгэхээр үндсэндээ 15, 6 жил болчихсон энэ үзэл баримтлалууд дээрээ бид нар тодорхой хэмжээний өөрчлөлтүүдийг хийж, эргээд эргэж харах шаардлага бол байна гэж харж байгаа. Энэ салбарыг бэхжүүлэх шаардлага бол байна гэж харж байгаа. Хүчтэй болгох, байлгах шаардлага байна гэж харж байгаа.

Мөн дээрээс нь бодлого, зарчим нь ч гэсэн илүү тодорхой байх зайлшгүй шаардлагатай байна гэж бол хараад байгаа юм. Тэгэхээр бол Гадаад харилцааны яамны зүгээс саяын энэ хууль, эрх зүйн орчинтой холбоотойгоор, засаглал, тогтолцоо, бүтэцтэй холбоотойгоор илүү өөрчлөлт шинэчлэлтүүдийг өнөөгийн цаг үеийн нөхцөл байдал болоод цаашдын ирээдүйн нөхцөл төлөв байдалд нийцүүлж илүү бодлогоо бас эргэж хараарай.

Үндсэндээ аль ч улс орны хувьд бол улс орныхон тэргүүлэх бодлогын чиглэл бол гадаад бодлого байдаг. Тэгээд бид нар энэ аюулгүй байдалтай холбогдсон, гадаад бодлоготой холбогдсон энэ бодлогууд дээр илүү ухаалаг байх, шийдвэр гаргах процесс маань, шийдвэр гаргалт маань өөрөө илүү зөв байх зайлшгүй шаардлагатай байгаад байгаа. Тэгэхээр бас түрүүний бас хэлээд байгаа илүү институцчилэгдсэн энэ шийдвэр гаргах процессоо илүү боловсронгуй болгох, илүү Гадаад харилцааны яам маань судалгаа, шинжилгээний процессоо илүү эрчимжүүлэх бол шаардлагатай байна гэж бол бас харж байгаа. Энэ дээрээ тухай

бүр бас бид бүхэнд бас мэдээллээр бол хангаж ажиллаж байгаарай гэдэг зүйлийг бас хэлэх байна.

Түрүүний тэр хүний нөөцийн бодлогын хувьд зөвхөн Элчин сайд нартай холбоотой асуудлууд биш. Энэ дипломат ажилтнуудаа мэргэжилтнүүдээ бэлтгэдэг институц, сургуулиудаа бол бэхжүүлэхэд бас анхаарч ажиллах зайлшгүй шаардлагатай байгаа. Бэлтгэсэн мэргэжилтнүүдээ мэргэшүүлэх чиглэлээр бас яам маань болж өгвөл уг нь бол Дипломат академийг байгуулж ажиллах шаардлагатай байна гэж бол бас хараад байгаа. Энэ дээр бол тодорхой анхаарч ажиллаарай гэдэг зүйлүүдийг бас дахиж чиглэл болгож хэлэх байна.

Бид бүхний хувьд энэ гадаад бодлогыг эрдэмжүүлэхтэй холбоотой асуудлууд дээр харилцаандаа болзошгүй эрсдэл болоод энэ сорилт, аюул бэрхшээлээс урьдчилан даван туулах үүднээс бол бас би хэлээд байгаа нь илүү шинжлэх ухааны үндэстэй, судалгаанд суурилсан, дээрээс нь болж өгвөл энэ тинк танк судалгааны хөгжүүлэлтүүдийг бас дэмжиж илүү ажиллах бол зайлшгүй шаардлагатай байгаа Засгийн газрын зүгээс.

Манай Байнгын хорооны зүгээс яг олон улсын харилцаа болоод энэ гадаад харилцааны чиглэлээр жилдээ 2 удаа бол намар болон хавартай энэ онол практикийн бага хурлуудыг бас энэ тинк танк хувийн судалгааны төвүүд болон судлаач нартай хамтарч бол зохион байгуулж байгаа. Энэ хаврын онол практикийн бага хурал бас энэ 5 сард бол болно. Болж өгвөл энэ хурлыг бид нар Гадаад харилцааны яаман дээр бол бас хийе гэсэн ийм бол төлөвлөгөөтэй байгаа. Тэгэхээр энэ дээр бас та бүхэн маань бас илүү анхаарч ажиллаарай л гэдэг зүйлийг бол бас онцолж хэлэх байна.

Цаашдаа саяын гишүүдийн хэлсэн саналууд дээр бас анхаарч ажиллаарай. Анхаарч ажиллаарай. Тэгэхээр үндсэндээ Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиар ажлаа шууд тайлагнадаг байгууллагууд холбогдох харьяа Байнгын хороонуудад мэдээлэл, тайлангуудаа хүргүүлэх бол Улсын Их Хурлын тухай хуулиар заасан үүрэг бол байгаа. Тэгэхээр энэ бол хувь хүний хоорондын харилцаа гэхээсээ илүүтэй төрийн ажил явж байгаа учраас асуудлууд дээр энэ холбогдох Байнгын хорооны хурлууд дээр бол бас илүү ажил хэрэгч байдлаар бол хандах шаардлагатай байна гэдэг зүйлийг эцэст нь бас онцолж хэлэх байна.

Ингээд мэдээлэл өгсөн Гадаад харилцааны яам болоод Батцэцэг сайд ба яамны хамт олонд баярлалаа. Мэдээлэл сонсож дууслаа.

Хоёр дахь асуудалдаа оръё.

17.08 цаг

Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг сонсоно.

Хуулийн хугацаатай ийм хэлэлцэх асуудал байгаа. Ирэх 7 хоногт Улсын Их Хурлаар орохоор байгаа. Ингээд биелэлтийн тайланг та бүхэнд Байнгын хорооны гишүүдэд бас тараасан байгаа.

Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг Энхбаяр сайд танилцуулахаар байна. Энхбаяр сайдад микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Байнгын хорооны эрхэм дарга, гишүүд ээ,

Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журмын 6-д заасны дагуу цахим системд хяналтад байгаа Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хамаарах 23 шийдвэрийн 121 заалтын биелэлтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг танилцуулж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд ирүүлсэн тайлан, мэдээллийн өгөгдлийн дата баазыг ашиглаж хийсэн бөгөөд анхан шатын нэгжээс шат дараалсан үнэлгээний тайланд нэгтгэсэн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

Энэ үйл явцад яам, агентлаг, орон нутгийн төлөөллийг оролцуулснаас гадна Канадын Мерит төсөл, UNICEF, Удирдлагын академийн зөвлөхүүдийн арга зүйн дэмжлэг, зөвлөмж, саналыг тусган ажилласан нь анх удаа бүх шатын оролцоог хангасан арга хэмжээ боллоо.

Мөн ажлын бүтээмж, үр дүнг нэмэгдүүлэхэд технологийн дэвшлийг ашиглаж тус Байнгын хороонд хамаарах шийдвэрийн биелэлтэд хиймэл оюун ухааныг ашиглан дүнг шинжилгээ хийж үзсэн болно.

2025 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 23 шийдвэрийн 121 заалтыг яам, агентлаг, аймаг, нийслэлд хэрэгжүүлж ажилласан нь 72.1 хувьтай байна. Нийт 66 заалт хэрэгжсэн. 38 заалт хэрэгжих шатад байна. Үүнээс удаашралтай, эрчимжүүлэх шаардлагатай 12 заалт, хэрэгжээгүй 14 заалт байгаагаас 13 нь удирдлага зохион байгуулалтаас, 1 нь санхүү, хөрөнгө оруулалтаас шалтгаалсан байна. Хугацаатай өгөгдсөн оны төгсгөлд гарсан буюу хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 3 заалт байна.

2025 оны жилийн эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн, бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан, тухайн шийдвэр хүчингүй болсон зэрэг шалтгаанаар 66 заалтыг Засгийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хяналтаас хасах үндэслэлтэй гэж үзэж Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Тайлант онд хэрэгжээгүй шийдвэрүүд нь төрийн байгууллагуудын удирдлага зохион байгуулалт хангалтгүйгээс шалтгаалжээ. Тухайлбал, төрийн байгууллагуудын түвшинд хариуцлагын тогтолцоо хангалттай бүрдээгүй, салбар хоорондын ажлын уялдаа сул, олон удаагийн бүтцийн өөрчлөлт хийгдсэн, төсөв, хөрөнгө оруулалтын эрэмбэ дараалал хангалтгүй, бодлогын болон хүний нөөцийн тогтворгүй байдал зэрэг нь хууль тогтоомжийн биелэлтэд сөргөөр нөлөөлж байна. Иймд Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийн 2025 оны жилийн эцсийн тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээ авахыг даалгасан. Үүнд:

Нууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлж салбар хоорондын уялдааг ханган бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, иргэдийн ахуй амьдрал болон салбарын хөгжлийн үзүүлэлтүүд хэрхэн нөлөөлж буйг үнэлж тооцож ажиллах.

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулахдаа зохицуулалт, утга, агуулгын хувьд давхардал, хийдэл, зөрчилтэй шийдвэр гаргахгүй байх. Санхүүгийн эх үүсвэрийг тусгах, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт хэрэгжихүйц байхад анхаарах, дижитал хяналт, их өгөгдөлд суурилсан үнэлгээ хийх, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг бодит цагт хянах, ил тод болгох чиглэлээр цахим шинэчлэл хийх санал боловсруулж танилцуулах.

Мөн хууль тогтоомжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтнуудад зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад даалгасан болно.

Цаашид Монгол Улсын төр Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлтийн талаар баримтлах бодлогыг эргэн харах, шинэчлэх, сайжруулах үндэслэл нэгэнт бий болжээ.

Хууль тогтоомжийн биелэлттэй холбоотойгоор Улсын Их Хурлын түвшинд ч анхаарах асуудлууд байна. Үүнд:

Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог* сонгогддог байгууллагуудад үүрэг даалгавар болгосон шийдвэрийн хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах үйл ажиллагааг гүйцэтгэх засаглалын байгууллагуудын түвшинд уялдуулах нэгдсэн байдлаар тайлагнах боломжийг бүрдүүлэх

Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэрийн талаар нэгдсэн бүртгэлийн систем үүсгэж, Засгийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сантай уялдуулах.

Гарч байгаа шийдвэрийг шуурхай дамжуулах, хяналтад авах

Улсын Их Хурлын байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдийн түвшинд шийдвэрийн хэрэгжилтийн явцыг цахим систем ашиглан улирал тутам танилцах боломжтой болох

Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил болон тухайн жилдээ бүрэн хэрэгжсэн болон бусад шалтгаанаар хяналтаас хасуулах шийдвэр, заалтын талаар Засгийн газартай тогтмол хамтарч ажиллах

Хууль тогтоомж, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны шийдвэр, Засгийн газрын бодлогын баримт бичигт заасан зарим заалт агуулгын хувьд давхцах, хуулиар ноогдуулсан чиг үүргийг дахин тогтоол хэлбэрээр албажуулах зэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16.1 Улсын Их Хурлаас Засгийн газар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон энэ хуулийн 10 дугаар

зүйлд зааснаас бусад Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ээлжит чуулган эхлэхээс 15 хоногийн өмнө Улсын Их Хуралд ирүүлнэ гэж заасан нь цаг хугацааны хувьд үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хангалтгүй байна.

Иймд цаг хугацааг уян хатан байдлаар зохицуулах шаардлагатай байна.

Тус Байнгын хороонд хамаарах шийдвэрүүдийн биелэлтэд анх удаа хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийсэн бөгөөд нийт заалтад хуулиар ноогдуулсан чиг үүргийг дахин үүрэгжүүлсэн заалт байхгүй. 35.5 хувь нь тогтоолын хэрэгжилтийг давтан баталгаажуулсан заалт байна. 1.7 хувь нь бодлогын баримт бичигтэй агуулгын огтлолтой заалт байна.

Иймд Улсын Их Хурлын холбогдох бүтцийн нэгжтэй хамтран хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийх ажлыг улам боловсронгуй болгож, Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэрийн биелэлт, үр нөлөө, хяналтыг сайжруулахыг хичээж байна.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хамаарах хууль, тогтоолын биелэлтийн 2025 оны жилийн эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийг хавсаргасан болно. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайдад баярлалаа. Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлантай холбогдуулаад оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Бат-Эрдэнэ, Шадар сайдын ажлын албаны зөвлөх Оюунцэцэг, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхтүшиг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Дашпүрэв, Батлан хамгаалахын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганхуяг дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбаяр, Зам, тээврийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Болор-Эрдэнэ, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Баяраа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бодлогын газрын дарга Болорчулуун, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Ерэн-Өлзий, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Очирбат, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Ганболд, Их Хурлын Тамгын газраас Тамгын газрын Дэд дарга Эрдэнэбат, Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын зөвлөх Алтантуяа, мөн тус газрын судлаач, ажилтан Анужин гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар Байнгын хороо Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг бас тодорхой заасан хугацаанд авч хэлэлцэх үүрэгтэй байгаа. Танилцуулгыг хүлээж авснаас 1 сарын дотор хэлэлцэнэ гэсэн үүрэгтэй. Ингээд дараа 7 хоногт Улсын Их Хурлын чуулганаар бас хэлэлцэгдэхээр байгаа. Энэ хүрээнд өнөөдөр Байнгын хорооны хурлаар энэ хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг бол бас ингээд хэлэлцэж байна.

Тайланг гишүүдэд цахимаар болоод хэвлэж бас тараасан байгаа. Тайланд хийсэн дүн шинжилгээ болоод танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя.

Тэмүүжин гишүүнээр тасалъя. Тэмүүжин гишүүн асуулт асууя.

Х.Тэмүүжин: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1.8-аас эхэлж байгаа. 4.1.2.1.16 иргэдийг чадавхжуулах, гамшиг, аюулаас сэргийлэх, авран хамгаалах, сэргийлэх, сургалт, авран хамгаалах зохион байгуулалтыг дэмжин ажиллах, орон нутгийн хамгаалалт, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах болон үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий үндэсний тогтолцоог бий болгоно.

4.2.1.14.Гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах хохирол барагдуулах үйл ажиллагааг шинэ шатад гаргана.

4.2.1.15.Тагнуулын үйл ажиллагаа болон нууц мөрдөн шалгах ажиллагааны зааг ялгааг тодорхой болгож, эрх зүйн орчныг тус тусын хуулиар зохицуулна.

4.2.1.13.Нууц мөрдөн шалгах ажиллагаанд тавигдах шүүхийн хяналтыг сайжруулж, тус ажиллагаанд өртсөн иргэнд мэдэгдэх, хүний хувийн мэдээллийг хамгаалах, зөрчигдсэн эрхээ шүүхээр хамгаалах хуулийн зохицуулалтыг бий болгоно гэх мэтчилэн ингээд маш тодорхой хэмжигдэхүйц ийм ажлууд байгаа. Улсын Их Хурал Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлаад яг 2 жил болж байна. Энэ чиглэлээр Засгийн газарт ямар нэгэн алхам байна уу? Засгийн газар энэ чиглэлээр хэрэгжүүлэх бодлого, төлөвлөсөн ямар нэгэн үйл ажиллагааны чиглэл, хариуцсан яам, хариуцсан эзэд ер нь байна уу? Яг үндсэндээ 2 жил зүгээр улс төрийн хэрүүл хиймээр байгаад дууслаа. Энэ сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд улс төржихгүйгээр ажил хийж болох боломжтой байсан хугацаагаа бүгдийг нь идээд, хэрчээд, жижиглээд яс тээрэмдэж байгаа шиг тээрэмдээд дуусгачихлаа. Одоо улс төржихгүйгээр ажил хийж болох энэ ганцхан чуулган байсан энэ хаврын чуулган. Эхлээд бас улс төр, эрх мэдлийн хэрүүл хийсээр байгаад дууслаа. Бодитой ажил хэрэг болохоор олигтойхон хуулийн төсөл Засгийн газраас огт өргөн баригдсангүй. 1, 2 төсөл өргөн барьснаа буцаагаад татчихсан. Ирэх намрын чуулган төсөв хэлэлцээд тэгээд Ерөнхийлөгчийн сонгууль гээд бужигнаад дуусна. Иргэнд хэрэгтэй хууль засагласан шиг засагладаг болоход чухал энэ бодлогууд хэзээ орж ирэх вэ?

Г.Тэмүүлэн: Тэмүүжин гишүүний асуултад хариулъя. Энхбаяр сайд асуултад хариулъя.

Б.Энхбаяр: Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр батлагдаад жил 6 сар болж байна. Жил 6 сарын хугацаанд 3 дахь Засгийн газар дээр явж байна. Үүний 1 жил нь бол таны асуусан эрхлэх асуудлыг танай намаас хамтарсан Засагт сайдаар томилогдож ажиллаж байсан. Тэгэхээр энэ бол их аль нэг намаас асуугаад байх асуулт биш байх гэж бодож байна. Төрийн бодлого тасралтгүй хэвийн үргэлжилж байгаа.

Таны ярьж байгаа жишээлбэл гэрч, хохирогчийг хамгаалах бие даасан хуулийн төсөл шинэ Хууль зүйн сайдын ширээн дээр байгаа. Би ажлын хэсэг байгуулаад, боловсруулж дуусаад холбогдох бүх байгууллагуудаас санал аваад

олон нийтийн хэлэлцүүлгийг нь хийгээд хууль тогтоомжийн хуульд заасны дагуу холбогдох судалгаануудыг хийгээд бүрэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн байсан. 4 сар Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажилласан. 2 сар хагасын буюу яг 75 хоногийн чуулганы ээлжит бус хугацаатай ажилласан. Нийтдээ 15 бие даасан хуулийн төслийг энэ хугацаанд боловсруулж дууссан. 6 бие даасан хуулийн төслийг Улсын Их Хурлын сая хаврын чуулганы эхэнд өргөн барьсан.

Тухайлбал, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Хар тамхитай тэмцэх бие даасан хуулийн төслийг өргөн барьсан. Төрийн нууцын хуулийг шинэчилсэн найруулгаар өргөн барьсан. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг мөн өргөн барьсан. Сууц өмчлөгчийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг өргөн барьсан. Одоо мөн Гэрч, хохирогчийг хамгаалахаас гадна таны асуусан гол асуудал бол Прокурорын байгууллагын тухай хууль байгаа.

Прокурорын байгууллага, мөн хуулийн байгууллагуудаас мөрдөн шалгахтай холбоотой, нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулахтай холбоотой ийм ер бусдыг эрүүдэн шүүсэн, хараат бус, бие даасан мөрдөх албаны тогтолцоог бүрдүүлэх үүргийг Засгийн газарт Улсын Их Хурлаас тогтоолоор өгсөн байгаа.

Прокурорын байгууллагын хууль, тэр дотроо прокурорын мөрдөнг яг Дорлигжавын үеийнх шиг биш өөрөөр хэлбэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан харьяалал хамаарахгүйгээр мөрдөн шалгадаг хэлбэрээр биш, нэн тодорхой хэргийн харьяаллыг тоочих хэлбэрээр Прокурорын мөрдөн байцаах албыг сэргээн байгуулах энэ хуулийн төслийг шинэ Хууль зүйн сайдын ширээн дээр ажлын хэсэг байгуулаад боловсруулаад бэлэн болгоод тавьчихсан байгаа.

Тийм учраас би энэ асуудлыг Хууль зүйн сайддаа бас хэлсэн байгаа. Амарсайхан сайдад энэ асуудлыг бас үргэлжлүүлж явуулах нь зүйтэй байх гэж бодож байна гэдэг байр сууриа хэлсэн. Яг Хууль зүйн сайдын эрхлэх асуудлыг би өмнө нь хашиж байсан юм гэдгээрээ ороод Улсын Их Хурал дээр байр сууриа илэрхийлээд байх нь туйлын зохимжгүй гэдгийг та бас хүлээж авах байх гэж бодож байна.

Тэмүүжин гишүүний тэр эхний асуултын талаар Батлан хамгаадах яамнаас хүн байгаа юу? Төрийн нарийн байгаа юм байна. Төрийн нарийн бичгийн дарга хариулт өгөөч.

Г.Тэмүүлэн: Тэмүүжин гишүүний асуултад нэмж тодруулж хариулья 2 номер Төрийн нарийн бичгийн дарга Ганхуяг дарга.

Д.Ганхуяг: Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганхуяг гишүүний асуултад хариулья Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх бодлогын бичиг баримтыг Батлан хамгаалахын сайд ахалсан ажлын хэсэг бэлэн болгосон байгаа. Яагаад түр хойшилсон гэхээр үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал шинээр өөрчлөгдөж байгаа. Энэ өөрчлөгдсөний дараа бид оруулахад бэлэн байгаа.

Орон нутгийн хамгаалалтын чиглэлээр бид хөгжлийн төлөвлөгөөнд бүсчилсэн маягаар сургалтын төвүүдийг барихаар тусган ингээд ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Тэмүүжин гишүүн нэмж тодруулж асууя.

Х.Тэмүүжин: Энэ 4.2.1.16-д дурдагдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн чинь гол агуулга нь уул нь Хууль зүйн яамны харьяа байгаа дотоодын цэргийг үндэсний гварди болгох 4 том чиг үүрэгтэйгээр орон нутгийн хамгаалалтын зохион байгуулалт, сургалтыг эрхлэх, гамшгаас сэргийлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хууль сахиулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, нэг нь болохоор үндсэн тэр онц чухал объектуудаа хамгаалах гээд энэ чиглэлээр ажилладаг нэг нэгдсэн суурь бүтэц үүсгэх зорилготой ингээд заалт биччихсэн юм. Энэ ганц Батлан хамгаалах яамны ажил ерөөсөө биш. Энэ Хууль зүйн яам, Батлан хамгаадах яам, Онцгой байдлын газар гэх мэтчилэн Засгийн газрын харьяанд байгаа энэ чиг үүргийн байгууллагууд дундаа нэгдсэн уялдаа бүхий дэд бүтэцтэй болох тухай яриа байхгүй юу. Тэгээд энэ чиглэлээр бодлого байгаа эсэх нь одоо хүртэл харагдахгүй байна. Энэ нь нөгөө яамнуудтай хамтарч ярьсан тийм яриа байгаа юм уу ер нь Шадар сайдтайгаа, Хууль зүйн яамтайгаа хамтарсан юм?

Г.Тэмүүлэн: Тэмүүжин гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Гараа өргөөрэй. Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Салбар дундын асуудал та мэдэж байгаа шүү дээ Засгийн газар яг ажлын 10 өдөр л болж байна шүү дээ. Нийтдээ 3 удаагийн өнөөдөртэй нийлээд хуралдаан хийлээ. Тэгээд таны хэлж байгаа асуудлуудыг би холбогдох эрхэлсэн Шадар сайд, Батлан хамгаалахын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарт уламжилъя.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Би товч бөгөөд тодорхой зарчмын 1 асуулт л асуух гэсэн юм. Яг Улсын Их Хурлаас болоод холбогдох Байнгын хороодоос баталсан хууль тогтоомжийн шийдвэрүүд, мөн дээрээс нь Засгийн газрын үйл ажиллагааны тайлангийн биелэлттэй холбоотойгоор яах вэ манай Их Хурлын Тамгын газраас дүн шинжилгээ бас хийсэн байгаа. Энэ дотроос яг үндсэндээ манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд үндсэндээ нийт Байнгын хорооны 10 тогтоолын 58 заалтын биелэлт 60 хувьтай гэж бол гарсан байгаа. 60 хувь. Улсын Их Хурлын 21 шийдвэрийн 112 заалтын биелэлт дунджаар 76 хувьтай гэж гарсан байгаад байгаа. Тэгэхээр би бас энэ үндсэндээ тайлангийн хэрэгжилтийн биелэлт бол бас хангалттай биш байна гэж бол үзэхээр байгаад байгаа юм. Тэгэхээр би нэг талдаа бол энэ зөвхөн нэг шалтгаанаас үүдэлтэй холбоотой асуудал биш л дээ мэдээж. Мэдээж юу гэдэг юм энэ улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн хүндрэл ч гэдэг юм уу, гадаад, дотоод орчны нөлөөллүүд мэдээж нөлөөлж байгаа. Мэдээж энэ бас төлөвлөлтийн алдаанууд бас байгаа. Санхүүжилтийн хүндрэлийн асуудлууд байна.

Дээрээс нь хяналт болоод, хүний нөөц, ил тод байдлын энэ засаглалын асуудлууд ч гэсэн нэлээн хүндрэл үүсэж байгаа гэж харж байгаа. Тэгэхээр би зүгээр энэ дээр цаашдаа бид нар ер нь энэ хууль тогтоох дээд байгууллагын баталсан тогтоол, шийдвэрүүдийг ер нь цаашид яаж хэрэгжүүлдэг болох юм бэ? Энэ дээр бид нар тодорхой хэмжээний бодлого гаргаж энэ асуудлуудыг бас бүрэн дүүрэн шийдвэрлэх энэ асуудлыг дээшлүүлэхгүй бол хариуцлагын тогтолцоо сул байгаа асуудлуудыг бас сайжруулахгүй бол үндсэндээ нөхцөл байдал бол бас ийм ёс төдий ингээд Улсын Их Хурлаар, Байнгын хороодоор энэ тайлангийн биелэлт гэсэн нэр төдий хэлэлцдэг нөхцөл байдал бол бас хэвээр үргэлжлэхээр байна уу гэж бас хараад байгаа юм.

Тэгэхээр энд анхаарах ёстой асуудлууд мэдээж юу гэдэг юм төлөвлөлтөөсөө бид нар бол анхаарах зайлшгүй шаардлагатай байх гэж хараад байдаг. Яг энэ яам, агентлагууд хоорондын чинь төлөвлөгөө хоорондоо нэгдүгээрт зөрөөд байх асуудлууд гарч ирж байгаа юм. Тэгээд тухайн Засгийн газрын тухайн тэр Их Хурлаас баталсан тэр бодлого, шийдвэрүүд хэрэгжилт дээр бол хөрсөн дээрээ буудаггүй, урт болоод дунд хугацааныхаа энэ бодлогынхоо уялдаа холбоо нь алдагддаг ч гэдэг юм уу, хөтөлбөр, зорилтууд нь бодит нөхцөл байдалтайгаа нийцдэггүй ийм дүр зураг бол гарч ирээд байгаа юм.

Дээрээс нь би хамгийн том асуудал бол үндсэндээ Засгийн газар дээрээ ч тэр, Их Хурал дээр ч ер нь бид нар бас өөрсдөө алдаа онооны асуудал байгаа нь энэ хяналт, шинжилгээ болоод энэ үнэлгээний чинь сул тогтолцооноос асуудал би өөрөө бас болоод байна гэж бол бас хараад байгаа юм. Тэгэхээр бид нар энэ дээр нэг талдаа Засгийн газар дөнгөж шинээр байгуулагдаад 2 долоо хонож байна. Тэгэхээр бид нар төрийн бодлого, шийдвэрүүд цаашид амьдрал дээр хөрсөн дээр бууж, өдөр тутам энэ асуудлууд нь шийдэгдэж, бодлого, шийдвэрүүд хэрэгждэг байх зайлшгүй шаардлагатай байна. Үр дүнг хэмжих тодорхой шалгуурууд нь өөрөө дутмаг байна. Тэгэхээр магадгүй тэр бодит гүйцэтгэлийг шалгах механизм нь сул байгаа энэ асуудлуудыг бас шинэчлэх тал дээр бас өөрчлөлт гарах зайлшгүй шаардлага бол байна уу гэж хараад байгаа юм.

Гурав дахь үндсэн асуудал үндсэндээ энэ хариуцлагын тогтолцоо өөрөө сул байгаад байна. Яг үндсэндээ энэ бодлого, шийдвэрүүдийг хэрэгжүүлээгүйтэй холбоотойгоор тухайн хариуцлага алдсан агентлаг, яам, тухайн холбогдох төрийн албан хаагч нар дээр хариуцлага тооцох механизм өөрөө сул байна гэж хараад байгаа юм. Тодорхой зүгээр цалингийн ч гэдэг юм уу, тодорхой нэр төдий ч гэдэг юм уу ийм хэмжээгээр. Өнөөдөр жишээ нь манай Байнгын хорооноос бас гаргасан шийдвэрүүдийн биелэлт 60 хувьтай, 70 хувьтай байлаа гээд аваад үзэхэд үлдсэн тэр 30, 40 хувийг нь хэрэгжүүлээгүй эрх бүхий албан тушаалтнууд дээр яах юм бэ гэдэг асуудал үүсээд байгаа юм. Тэгээд энэ болгоныг бид нар илүү үүрэг хариуцлагын зааг энэ хязгааруудыг нь бол тодорхой болгох зайлшгүй шаардлага байна уу гэж бол бас хараад байгаа юм.

Дахиад үндсэндээ бас нэг асуудал нь үндсэндээ энэ мэдээллийн ил тод байдлын асуудал, хүртээмжийн асуудал өөрөө их сул байгаад байдаг. Тайлангууд өөрөө их олон нийтэд хүртээмжгүй, ойлгомжгүй, хэт ерөнхий, нээлттэй мэдээлэл дутмаг, иргэдийн оролцоо сул ч гэдэг юм уу ийм асуудлууд байгаад байгаа учраас цаашид бид нар энэ системээ сайжруулахын тулд Улсын Их Хурлаас баталсан тогтоол, шийдвэрүүд хэрэгждэг байхын тулд системийн түвшний ийм шинэчлэлийг бол шаардлагатай байна гэж хараад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр Хэрэг эрхлэхийн дарга бас шинээр дөнгөж ажлаа аваад бас удаагүй байна. Та бас энэ дээр яг бодитоор дүн шинжилгээ хийгээд дараа жил өдийд бид нар энэ хууль, тогтоол, тогтоомжийн шийдвэрийн биелэлтийг гаргахад арай илүү өөрөөр ханддаг байх ийм шаардлага бол байна уу гэж хараад байгаа юм.

Яах вэ мэдээж Байнгын хороод тухай бүр энэ өнөөдөр сая энэ Гадаад харилцааны яамны тайлан, мэдээллийг сонсож байгаа шиг тухайн тавигдсан үндсэн асуудлуудаа нэхэж шаардаж байгаа шиг ийм байдлуудын асуудлууд тавиад явна. Гэхдээ нэгдсэн цогц байдлаар Улсын Их Хурал л нь ч тэр, Засгийн

газар нь ч тэр илүү өөр түвшний шинэчлэлүүдийг бас энэ хяналт шинжилгээтэй холбоотойгоор хийх шаардлага бол байна гэж хараад байгаа юм.

Би зүгээр саяын манайхаас баталсан хууль тогтоомжууд дээрээс хэрэгжээгүй зүгээр энгийн ганцхан жишээг хэлье л дээ. Одоо би манай Дашпүрэв гээд Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга байх шиг байна. Энэ дээрээс ганцхан заалт би зүгээр жишээ болгож л хэлж байгаа юм шүү. Та одоо жишээ нь яг бодит хэрэгжилт нь ямар байна гээд. Энэ үндсэндээ Аюулгүй байдлын байнгын хорооноос бид нар 22 онд баталсан тогтоолын 1.4 дэх заалт байгаад байгаа юм. Тэгээд энэ өөрөө юу юм бэ гэхээр үндсэндээ бид нар түүхий эдээр тогтвортой нөөцөөр хангах бэлтгэл ажлыг зохион байгуулах газрын тосны хайгуул судалгааны ажлыг эрчимжүүлэх, шинээр нөөцийг тогтоох, ашиглах үйл ажиллагааг дэмжих гэдэг энэ заалт бүүр тодорхой зааж өгч байсан. Одоо үндсэндээ энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн чинь түүхий эдийн асуудал бусад бүх Байнгын хороод дээр хэрэгжиж байгаа асуудлууд болчихоод байна л даа. Гэтэл манай Их Хурлын Тамгын газраас энэ дээр дүн шинжилгээ гээд гаргаад ирэхээр 24 оныхоо жилийн эцсийн тайланг хуулж тавьсан байна гэж байгаа юм. 24 оныхоо. 25 онд энэ дээр ямар зохион байгуулсан тодорхой ажил байхгүй байна гэж харж байгаа юм.

Тэгэхээр чинь юу гэдэг юм зөвхөн нэг ажил нь ийм байвал цаашид бид нар яах юм бэ гэдэг зүйл байгаад байдаг. Энэ чинь үндэсний хэмжээний стратегийн том асуудал дээр бид нар ийм хариуцлагагүй хандаж болж байгаа юм уу гэдэг асуудлууд байгаа. Тэгэхээр одоо бол энэ дээр та хэд маань бас анхаарч ажиллаач ээ. Зөвхөн энэ асуудал биш би том бодлогын түвшинд анхаарч ажиллаач ээ л гэдэг зүйлийг хэлэх гэсэн юм. Энхбаяр сайд та байр сууриа илэрхийлэх үү? Ер нь том бодлогын түвшинд яах вэ гэдэг зүйл дээр.

Б.Энхбаяр: Би Тэмүүлэн даргатай санал нэг байна. Тэгэхээр ер нь засгийн гүйцэтгэх эрх мэдлийн түвшинд парламентаас баталж байгаа энэ бодлогын шийдвэрүүдийн хэрэгжилт, мониторингийн асуудлыг аргачлалын хувьд, үнэлгээний хувьд, хүний энэ чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийн хувьд бас цогцоор нь анхаарахгүй бол болохгүй юм байна гэж би дүгнэж байгаа. Энд би их ерөнхий байдлаар хэлж байгаа.

Тэгэхдээ Засгийн газар бол энэ гүйцэтгэл дээр хангалтгүй нөлөөлөхөд төрийн байгууллагуудын удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, хариуцлагын тогтолцоо хангалттай бүрдээгүй гэж бид гүйцэтгэх эрх мэдэл дээр байгаа шалтгаан нөхцөлийг тэргүүн ээлжид өөрсдөө хүлээн зөвшөөрч байгаа. Яг улс төржиж ярьж бас их тийм байхад их төвөгтэй юм байна.

Жишээлбэл, Засгийн газрын энэ тайланг гүйцэтгэх эрх мэдлийн Их Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газрын түвшинд мониторинг хийх нэгжийг татан буулгачихсан байсан. 23-аас 25 оны хугацаанд 2 жил. 25 оны 7 сараас энэ нэгжийг 4 хүнтэйгээр шинээр байгуулж байх жишээтэй жишээлбэл. Тэгээд бүх зүйлүүдийг дахиад шинээр ингэж зохиож хүмүүсээ сургах аргачлалыг боловсруулахаас эхэлж байх жишээтэй. Засгийн газрын хяналтын хэрэгжүүлэгч тухай хууль гээд бид нар баталж байсан. Та бүхэн мэдэж байгаа байх. Хэн оруулж ирээд баталж байсныг бас мэдэж байгаа байх. Тэр хуулиар энэ нэгжийг байхгүй болгочихсон байгаа байхгүй юу. Чиг үүрэг нь байхгүй.

Тэгэхээр ямар би парламентын баталсан хууль бас буруутай гээд би парламенттайгаа бие биеийгээ толхилцоод байх бидний хамтын шийдвэр байсан. Тэгээд бодит байдал ийм л байна. Маш их олон үндэсний зөвлөл, хороод байсан. Татан буулгасан. Дахиад ч татан буулгаад явж байна. Хэрвээ та бүхэн анзаарах юм яг хамтарсан Засгийн газар эхлээд улс төрийн нөгөө парламентын, энэ чинь парламентын 126 гишүүний 92 хувийг нэгтгэчихсэн хамтарсан Засгийн газар ажиллаж байсан шүү дээ. Сөрөг хүчин гэж байхгүй. Сөрөг хүчин байгаагүй шүү дээ. Тийм нэгдлийг бий болгочихсон байсан шүү дээ. Парламентын ардчилал, бид дархлаа эд нар ярих юм бол. Сонгодог парламент эд нар гэж хэлэх юм бол тэрнийхээ эсрэг. Тэгээд тэрнээс улбаалаад юу болчихсон гэхээр одоо зөвхөн 1 сайд дээр байх ёстой 1 ажлыг 4 сайдын эрхлэх асуудал дээр хуваачихсан ийм бүтцээр ажиллаж байсан. Одоо гадаад худалдааны асуудал яг хэн дээр байна? Гадаад худалдаа Гадаад хэргийн сайд дээр байна. Бүсийн хөгжил нь Шадар сайд дээр байна. Төр, хувийн хэвшлийн түншлэл чөлөөт бүс нь Тэргүүн шадар сайд дээр байна. Тэр төрийн хил дээр худалдааг хариуцсан боомт, захиргаа нь болохоор Сангийн сайд дээр байж байна энэ хар аа. Тэрийг ажиллуулж байгаа төрийн өмчийн компани нь Хэрэг эрхлэхийн сайд дээр байж байна. Энийг давхардсан би хүнийх нь тоог нь хариуцсан хүмүүсийг нь ингээд ярих юм бол энэ бүүр.

Тэгэхээр яагаад Учрал Ерөнхий сайд гарч ирээд сая өнөөдрийн Засгийн газрын хуралдаанаар бид Засгийн газрын сайдуудынхаа, агентлагуудынхаа бүх эрхлэх асуудалд маш богино хугацаанд энэ 4 сардаа багтаагаад чиг үүргийн шинжилгээ хийж байгаа юм. 4 сарын 26-ны Засгийн газрын хуралдаанаар бид энэ чиг үүргийнхээ шинжилгээний үр дүнд энийг оновчтой болгох шийдвэр гаргая гээд Засгийн газар дээр Хэрэг эрхлэхийн сайд миний бие хариуцаад ажиллаж байгаа.

Тийм учраас чиг үүргийг нь эхлээд оновчтой болгох ажлыг хариуцуулахгүй бол нэг ажил нэхэхээр сүүлдээ эзэн нь олдохоо больчихно. Алдаа, дутагдал гарвал хэн хариуцах вэ? Бие бие рүүгээ чихээд байдаг. Яг хариуцъя гэхээр би ч хариуцдаггүй тэрийг нь энэ хариуцдаг энэ хариуцдаг гээд бие бие рүүгээ чихээд суугаад байдаг. Тэгэхээр энэ өөрөө удирдлагын зохион байгуулалтын алдаа болсон гэдгийг, байсан гэдгийг би хүлээн зөвшөөрч байгаа юм. Тийм учраас ажлаа эндээс эхлэх ёстой гээд Засгийн газар байгаа онилж харьчхаад ажлаа эхлүүлж байгаа юм.

Тийм учраас Улсын Их Хуралтайгаа бас энэ чиглэлд хамтарч ажиллая гэж бодож байгаа. Бид жишээлбэл энэ тайланг хэлэлцэх дээр Хууль тогтоомжийн хуулийн дагуу дэгийн хууль дээр юу орчхоод байна вэ гэхээр жилд 2 удаа энэ тайланг бүх Байнгын хороогоор оруулаад байгаа юм. Тэгээд энэ яг үр дүнтэй тайлагнал мөн үү? Тэгээд ийм цаасан хэлбэрээр.

Ер нь гишүүддээ Засгийн газрын түвшинд Ерөнхий сайд юу яагаад байгаа гэхээр ерөөсөө энэ dashboard дээр байгаа бүх төрлийн мэдээллүүдийг сайд нар ерөөсөө ямар ч түвшинд албан хаагчдаасаа нэхэхгүй ээ цаасаар гэж байгаа. Энэ тайланг Их Хурлын гишүүдтэй ерөөсөө шууд холбоё. Их Хурлын гишүүд маань ерөөсөө энэ тайлангаас “real time” холбогдож мэдээллээ авдаг тайлангийн үнэлгээтэй танилцдаг ийм юмыг л хөгжүүлчихье гэдэг ийм зорилттой байж байгаа. Тэгвэл заавал жилд тэдэн удаа ч юм уу, бичгээр ч гэдэг юм уу энэ олон төрийн энэ чинь дандаа яг өдөр тутам ажлаа хариуцаж байгаа Төрийн нарийн бичгийн дарга гээд, газрын дарга нар бас энд ингээд байгаад байгаа юм. Хойно нь бас ажил нь хохироод байгаа л гэсэн үг. Тийм учраас энэ “real time” парламентынхаа хяналтыг

тавьдаг, танилцдаг, асуудаг ийм ийм цахим технологийг ер нь Засгийн газрын түвшинд тэр, Их Хурлын түвшинд тэр хөгжүүлээд явбал аль алиндаа амар юм биш үү гэсэн ийм л байдалд зорилго тавиад л ажиллаж байна даа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тайлангийн биелэлттэй холбоотойгоор үг хэлэх гишүүд байна уу?

Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг чиглэл болгосон, Улсын Их Хурлаас баталсан шийдвэрийг ойлгоогүй хүмүүс хэрэгжүүлнэ гэж байхгүй л дээ. Ярьж байгаа зүйл нь огт ойлгоогүй байна шүү дээ. Тэгээд өөрөө өөрсдийнхөө бодлыг яриад сүүлдээ Улсын Их Хурал бидэнд яаж хяналт тавих тухайг Засгийн газар нь заах юм байна л даа. Хөл, толгой алдагдаж байгаагийн том хэлбэр энэ болно шүү дээ. Улсын Их Хурал Засгийн газрын үйл ажиллагаанд мөрийн хөтөлбөр дотор Мөрдөх алба байгуулах тухай маш тодорхой заалт оруулсан. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо энэ хар тамхи, мансууруулах бодистой холбоотой асуудлаар тусдаа мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллага байгуулах тухай маш тодорхой үүрэг, даалгавар өгсөн. Энэ хоёр чинь нэг зүйл байсан. Олон улсын жишгээр улс дамнасан энэ төрлийн гэмт хэргийг одоо байгаа дотоодод байгаа цагдаагийн арга барил буюу хүч нөөцөөр энэ гэмт хэрэгтэй тэмцэж чадахгүй юм байна.

Тийм учраас Мөрдөх албаа байгуулаач ээ. Хар тамхи, цахим гэмт хэрэг, хүн худалдаалах дандаа улс дамнаж хийгддэг. Зүгээр үндэсний дотоодод байдаг гэмт хэрэг ерөөсөө биш. Маш том эдийн засгийн сонирхолтой. Орлого, бизнесийнх нь хүрээ нь хэвийн бизнесээс хамаагүй томорчихдог. Тэрүүгээрээ ингээд зохион байгуулалтад нарийвчлаад орчихдог. Тэгээд үйлдэгдэж байгаа гэмт хэргийнх нь газар нутгийн байрлал нь нэг улсын нутаг дэвсгэр дээр биш дандаа хил дамнаж үйлдэгддэг энэ төрлийн гэмт хэрэгтэйгээ тэмцэх хүч нөөц, боловсон хүчин, зохион байгуулалт, зардал мөнгөнийхөө асуудлыг Мөрдөх албаны хэмжээнд зохион байгуулаач ээ гэдэг үүрэг чиглэлийг өгсөн. Засгийн газар гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг Үндсэн хуулиараа байж байгаа.

Гэтэл өөрийнхөө гүйцэтгэх эрх мэдлээс гадна прокурорын мөрдөн байгуулах тухай яриад сууж байна гэдэг чинь угаасаа энэ бодлогыг ойлгоогүй байна гэсэн үг шүү дээ. Энэ баримт бичгээ бүүр тоож уншсан юм уу ер нь? Тийм хэмжээнд юм байна гэсэн байгаа нь харагдаж байгаа байхгүй юу. Алдаагаа дахин дахин давтаад байвал Ардын нам ухсан нүх рүүгээ улам бүүр гүнзгийрүүлж оруулах байх. Танай намын өнгө аашаар энэ улс орны хувь заяа явж болохгүй шүү дээ. 2016 оноос хойш манай намаас Ерөнхийлөгч гарчихна гэж горьдоод Элбэгдорж дээр өчнөөн эрх мэдэл нэмсэн. Сайн дураараа хадаг барьж гүйсээр байгаад М.Энхболд гэдэг хүн Ерөнхийлөгч болно гэж горьдож гүйсээр байгаад Ерөнхийлөгчийг Ерөнхийлөгч биш болтол нь 200 хуулиар эрх мэдэл нэмээд өгчихсөн. Баттулга болчихсон чинь зовлонг нь авангуутаа Үндсэн хуулиа өөрчилж байгаад очиж болтугай Ерөнхийлөгчийн эрх мэдлийг танах ёстой гээд 19 онд өөрчлөлт оруулсан. Танай намын л хийсэн ажил шүү дээ.

Дараа нь өөрийнхөө Ерөнхийлөгч гараад ирэхээр бүгдээрээ нөгөө Үндсэн хуулийн өөрчлөлт гараад хийгээд Баттулгыг хэн ч биш болгоно гэж байсан бодлогоосоо өөрчлөгдөөд бүгд хадаг бариад гүйцсэн. Ирэх сонгуулиар танай

намын Ерөнхийлөгч гарахгүй шүү дээ. Энэ зовлонгоо хэд дахин үүрэх гэж байгаа юм? Эрх мэдэлтнийг дагаж хадаг дээр албан тушаал эрх мэдэл хоёрыг барьж гүйсээр байгаад танай намын энэ даргаа шүтдэг бялдуучилсан зовлонгийн чинь гайгаар энэ улс орон 2 удаа нэг бол Ерөнхийлөгчтэй, нэг бол Ерөнхийлөгчгүй, нэг бол дарангуйлагчтай, нэг бол өөр юмтай болж хувираад ингээд жүжиг тоглож дууслаа шүү дээ. Хэдий болтол намынхаа дарга нарын эрх мэдлийг тэлж нэмэх гэж энэ хадаг дээр төрийг барьж тоглодгоо болихыг зогсоох юм бэ? Ингээд нэг нэгэндээ нэр өгөөд нэг нэгнийгээ хулгайд зарлаад тэгээд сүүлдээ танай намаас болж Монгол Улсын төр хямарч байна шүү дээ. Үндсэн хуулийн байгуулал нурж унаж байна шүү дээ. Могойныхоо ажлыг нам дотроо л хийдэг юм байгаа биз. Төр дотор хийж болохгүй шүү дээ.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа. Ингээд хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг Байнгын хороонд ирүүлснийг асуудал бүрээр Байнгын хороо хэлэлцэж дууслаа.

Ингээд ажлын хэсгийнхэнд баярлалаа. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан байна. Идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

17.43 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР